

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Аян замын тэмдэглэл нь: Бичигч гадаад улс орон болон эх аялж явах, томилолтоор ажиллах явцад ажиглагдсан шинэ сонин зүйл, тэдгээр орны хөгжил цэцэглэлт, ард түмний аж байдал, зан заншил, нийгмийн байгууллын онцлог, байгалийн өвөрмөц үзэгдэл, үйл явдал зэргийг уншигчдад сонирхуулах, танин мэдүүлэх зорилгоор бичдэг. Бичигчээс өргөн дэлгэр мэдлэг, ажигч гярхай чанар шаарддаг, тусгах зүйлийн цар хүрээ ихтэй, мэдээллийн багтаамж сайтай, танин мэдэхүйн ач холбогдолтой, тодорхой асуудлуудыг ч тусгадаг сонирхолтой бичлэгийн төрөл юм.

Эхэд өгүүлэгдэж буй зүйлс бүхэлдээ эхийн агуулгыг бүрдүүлдэг. Эхийн агуулгыг эхлэл, гол, төгсгөл гэсэн үндсэн 3 хэсэгт хуваана.

Эхлэл хэсэг: Эхэд өгүүлэгдэх зүйлийн суурь мэдээлэл

Гол хэсэг: Эхийн гол санааг дэлгэрүүлсэн хэсэг

Төгсгөл хэсэг: Эхийн санааг нэгтгэн дүгнэсэн хэсэг.

Эхийн мэдрэмж гэдэг нь: Харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүртэх 5 мэдрэхүйгээр дамжин илрэх онцгой чадвар бөгөөд зарим зүйлд хариу үйлдэл үзүүлэх, түүнийг таних, үнэлэх, ойлгох чадвар юм. Мэдэрч чадсанаар аливаа зүйлийг тусган авч түүнээсээ сэтгэгдэл үүсдэг. Тухайлбал, аливаа зүйлийг хараад, сонсоод "...яасан сайхан юм бэ" "... ээ тун хэцүү харамсалтай" "... мөн ч уярам уянгалаа" гэх зэргээр янз бүрээр мэдэрч хүлээж авдаг.

Сэтгэгдэл нь: Бодож сэтгэгдсэн юм буюу хүн, юм үзэгдлийн талаар төрсөн санаа, мэдрэмжээр дамжин чамд төрсөн бодол юм. Яаж мэдэрч хүлээж авснаас сэтгэгдэл төрнө. Тухайлбал, "... мөн ч уярам уянгалаа " гэж мэдэрсэн бол "энэ уянгалаа аялгуунаас хөгжмийн утас бүрийн дуу хөг нь тансаг сайхан юм аа" гэсэн сэтгэгдэл төрж төрж байна" гэх жишээтэй.

Үзэл бодол: Ямар нэг асуудлын талаарх хувь хүний байр суурь, шийдвэр юм.

Дэвшүүлсэн асуудал: Тухайн зүйлээс үүдэн дэвшүүлж буй санаа, санал гэж ойлгож болно.

Баймж утга: Хүний сэтгэлийн өнгө аясыг илэрхийлдэг.

Даалгавар 1. Аян замын тэмдэглэлийн бүтэц агуулгын уялдаа холбоог задлан шинжилж, сэдэв гол санааг тодорхойлох

Аян замын тэмдэглэлийг уншиж ойлгоод дасгалыг ажиллаарай.

Архангайн замд

1976 оны бороо ногоо тэгш сайхан зун С. Эрдэнэ тэргүүтэй хэдэн зохиолч уул даваа, ус гол гаталсан урт зам туулж, Архангайн Хорго, Тариат хүрлээ. Шөнө нь бороо орж, өдөр нь нар гарч, цаг агаар тусгай хөтөлбөртэй мэт байв. Гол усны хөвөөн дээр майхнаа барин, хээр хөдөө унтаж, өглөө нь машиндаа ачаалан, аян замдаа гарна.

Нэг өдөр бид хэд Хоргын тогооны ирмэг дээр зогсож байлаа. Гүн ёроолдоо хар ногоон устай энэ "тогоо"-г хадан ирмэг дээрээс нь харахад аймаар, хөл алдвал дууслаа гэж бодсон сон.

Хорго үзсэний дараа С. Эрдэнэ нэг орой "Би нэг шуналтай хүний тухай бичих санаа оллоо. Хомхой шуналаасаа болоод галт уулын тогоо руу орчихсон хүний тухай "Занга" богино өгүүллэг бичье" гэж тэр дороо л шинэ санаа олж бидэнд яриу.

Дууссан:онсарөдөр

Хорго, Тариатын нутгаас буцаж явахдаа бид Суман гол, Чулуут голын бэлчир дээр хүрч ирлээ. Хоёр ширүүн гол хар эрчээрээ явж, нэгэн хавцалд уулздаг аж. Зохиолч С. Эрдэнэ үүнийг “Цагаан устай Чулуут, хар устай Суман, хадан цээжтэй хатуу газрыг хага цохин нийлжээ. Нийлэх гэж тэмүүлэн тэмүүлсээр үүрд салшгүй нийлжээ. Чулуут, Суман хоёр эвлэрэн нийлэх гэж үзэлцсэн нь үнэхээр залуу хар эрээн барс, цагаан арслан хоёр уулнаас үсрэн бууж ноцолдон байх мэт” гэж уран сайхан дүрээр буулган хэлж байлаа...

Долгорын Нямаа

Алхам 1: Эхийн сэдэв, гол санаа, агуулгын талаарх мэдлэг ойлголтоо сэргээн санаж, цэгийн оронд тохирохыг нөхөөрэй.

А. Зохиогчоос уул эхийн санааг гаргах гэж сэдсэн /сэдэл/ санааг _____ гэнэ. Өөрөөр хэлбэл тухайн өгүүлэгдэж буй юмнаас үүдэлтэй санаа нь гэж ойлгож болох юм.

Б. Зохиолын сэдвийг гол үйл явдлаар дүрсэлж дүгнэлт гаргахыг _____ гэнэ. Өөрөөр хэлбэл агуулгаар дамжуулан илэрхийлж буй санаа юм.

В. Эхэд өгүүлэгдэж буй зүйлс бүхэлдээ _____-ыг бүрдүүлнэ.

Алхам 2. Эхийн агуулгыг цогцолбороор зааглан бичнэ үү.

Эхэд: _____

гэсэн _____ цогцолбор байна.

Алхам 3. Цогцолборын агуулгыг зөв харгалзуулаарай.

- | | |
|---|------------------|
| 1. Нэгэн сайхан зун зохиолчид аян замд гарав. | A. 2-р цогцолбор |
| 2. Хоргын тогоог үзэхэд төрсөн мэдрэмж | B. 3-р цогцолбор |
| 3. Хоргын тогоог үзэхэд төрсөн сэтгэгдэл | C. 1-р цогцолбор |
| 4. Хорго, Тариатаас буцах замд... | D. 4-р цогцолбор |

Хариулт бичих хэсэг: _____

Алхам 4. Эхийн агуулгын бүрдэл хэсгийг зөв тодорхойлж бичихдээ зохиогч хэрхэн төлөвлөсөн байж болохыг таамаглан бичээрэй. Үлгэрлэвэл: 4 дэх цогцолбор буюу Хорго Тариатаас буцсан тухай өгүүлж буй хэсгийг бүхэлд нь төгсгөл хэсэг гэж үзвэл зохиогч эхийн гол санааг нэгтгэн дүгнэх замаар тэмдэглэлээ төгсгөсөн байж болох юм.

Эхлэл хэсэгт:

Гол хэсэгт:

Төгсгөл хэсэгт:

Алхам 5. Эхийн сэдвийг зөв тодорхойлоорой.

- A. Байгалийн сайхны тухай
- B. Архангай аймгийн тухай
- C. Чулуут гол, Суман гол 2 нийлж урсдаг тухай
- D. Зохиолчдын аян зам, аяллын тухай

Алхам 7. Эхийн гол санааг хэрхэн тайлбарлавал оновчтой байх бол?

- A. Цаг агаар маш сайхан байсан.
- B. Хоргын тогоог дээрээс нь харахад аймаар.
- C. Байгалийн сайхан нь хүний сэтгэлийг хөдөлгөж, онгодыг хөглөдөг.
- D. Байгалийн үзэсгэлэнт газруудаар аялж зугаалах сайхан байдаг.

Алхам 8. Эхийн сэдэв, гол санаа, товч агуулгыг зөв харгалзуулаарай.

1. Аян зам, байгалийн сайхан нь зохиолч хүнийг уран ярууд хөтөлж, бичих туурвих санааг төрүүлдэг.

A. Эхийн сэдэв

2. Нэгэн зун хэсэг зохиолчид Архангайн Хорго, Тариат, Суман гол, Чулуут голоор аялан явжээ.

B. Эхийн товч агуулга

3. Аян зам, аяллын тухай

C. Эхийн гол санаа

Алхам 9. Дараах хэлцүүдээс эхийн гол санаанд тохирохыг сонгоно уу?

- A. Явсан нохой яс зууна
- B. Юм үзэж нүд тайлах
- B. Суусан газраасаа шороо атгах
- Г. Аавын бийд хүнтэй танилц, агтны бийд газар үз.

Ямар учраас эхийн гол санааг илэрхийлнэ гэж бодов?

Алхам 10. Аян замын тэмдэглэлийн бүтэц, агуулгын уялдаа холбоо, сэдэв, гол санааг ойлгохын тулд хэрхэн задлан шинжилдэг болохыг товч бичнэ үү.

Дасгал 2. Аян замын тэмдэглэлд байгаа зохиогчийн мэдрэмж, сэтгэгдэл, дэвшүүлсэн асуудлыг задлан шинжилж дүгнэх



Мэдрэмж гэдэг нь: Харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүртэх 5 мэдрэхүйгээр дамжин илрэх онцгой чадвар бөгөөд зарим зүйлд хариу үйлдэл үзүүлэх, түүнийг таних, үнэлэх, ойлгох чадвар юм. Мэдэрч чадсанаар аливаа зүйлийг тусган авч түүнээсээ сэтгэгдэл үүсдэг. Тухайлбал, аливаа зүйлийг хараад, сонсоод "...явсан сайхан юм бэ" "... ээ тун хэцүү харамсалтай" "... мөн ч уярам уянгалаг" гэх зэргээр янз бүрээр мэдэрч хүлээж авдаг.



Сэтгэгдэл нь: Бодож сэтгээгдсэн юм буюу хүн, юм үзэгдлийн талаар төрсөн санаа, мэдрэмжээр дамжин чамд төрсөн бодол юм. Яаж мэдэрч хүлээж авснаас сэтгээгдэл төрнө.

Тухайлбал, "... мөн ч уярам уянгалаг " гэж мэдэрсэн бол "энэ уянгалаг аялгуунаас хөгжмийн утас бүрийн дуу хөг нь тансаг сайхан юм аа" гэсэн сэтгээгдэл төрж байна" гэх жишээтэй.

Үзэл бодол: Ямар нэг асуудлын талаарх хувь хүний байр суурь, шийдвэр юм.

Дэвшүүлсэн асуудал: Тухайн зүйлээс үүдэн дэвшүүлж буй санаа, санал гэж ойлгож болно.

Баймж утга: Хүний сэтгэлийн өнгө аясыг илэрхийлдэг.

Эхийг уншиж ойлгоод дасгалыг ажиллаарай.

...Халуун шөнө унтах гэж их бүгчимдлээ. Өглөө цайгаа уугаад азарган тахиа олж ирэхээр шороон замаар нэлээд яваад, архи пивоны шил хөглөрсөн нэгэн газар ирлээ. Ямар их шил байна аа! Түүнийг хараад би гайхлаа, бас харамслаа. Манай зарим газар иймэрхүү дүр зураг харагддагийг саналаа. Монголд байхдаа анзаардаггүй байсан ч гадны оронд ирээд өөрсдийнхөө арчаагүй байдлыг мэдрэх сэтгэл төрдгийг энд ойлголоо. Эд бол архи сархдад дарлуулж буй хүмүүс байна ... Ардын засаглалын үед манайд архи, ундааны шилийг буцаан авч, дахин ашигладаг байсан системийг Европын орнууд хэрэглэж эхэлж байна. Үүнийг аль ч улс оронд хэрэгжүүлбэл хэрэгтэй санагдлаа... /Ж.Золбаяр/ 9 10 15 103 38 69

Алхам 1. Аян замын тэмдэглэлээс зохиогчийн мэдрэмжээ илэрхийлсэн үг хэллэгийг ялган бичээрэй.

Алхам 2. Аян замын тэмдэглэл дэх зохиогчийн мэдрэмж, сэтгэгдэл, дүгнэлт, баймж утга бүхий үг, өгүүлбэрийг зөв харгалзуулаарай.

1. Баймж

A. Монголд байхдаа анзаардаггүй байсан ч гадны оронд ирээд өөрсдийнхөө арчаагүй байдлыг мэдрэх сэтгэл төрдгийг энд ойлголоо.

2. Дүгнэлт

B. Эд бол сархдад дарлуулж буй хүмүүс байна.

3. Сэтгэгдэл

C. Ямар их шил байна вэ?

4. Мэдрэмж

D. Түүнийг хараад би гайхлаа, бас харамслаа.

Алхам 3. Зохиогчийн дэвшүүлсэн асуудлыг тодорхойлоорой.

A. Хог хаягдлыг дахин боловсруулах хэрэгтэй.

B. Гадны оронд ирээд өөрсдийнхөө арчаагүй байдлыг мэдэрдэг.

C. Ардын засаглалын үед манайд архи ундааны шилийг буцаан авч ашигладаг байсан.

D. Манай зарим газар иймэрхүү дүр зураг харагддаг.

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Хүн, юм, үзэгдэл, газар орон болон үйл явдлыг нүдэнд харагдтал дүрслэн бичихдээ дараах хэдэн асуултыг өөртөө тавьж түүндээ хариулж бичихийг хичээгээрэй.

Дүрслэхээр сонгож авсан зүйлийн хамгийн содон шинж, эсвэл чухал зүйл нь юу байна вэ?

Энэ нь чамд ямар мэдрэмж төрүүлж байна вэ?

Эдгээрийн тухай сэтгэгдлээ эхэд хэрхэн тусгах вэ?

Уншигчид яаж сонирхолтой байдлаар хүргэх вэ?

Даалгавар 3. Дүрслэн бичихдээ орон цаг, нөхцөл байдлыг дүрсэлж, мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэн аяллын тэмдэглэл (аян замын) бичих

Алхам 1. Аяллын тэмдэглэл бичихийн өмнө санаагаа цэгцэлж бэлдэхийн тулд дараах асуултад хариулт хайгаарай. Хариултаа ноороглон буулгаж ерөнхий санаагаа гаргаж бичээрэй.

- Хэзээ?, хаана?, яагаад?, (ямар учраас, юунаас болж) хэн? юуг? яав? гэсэн асуултаар бичих)
- Цогцолборуудыг болон үйл явдал түүний юунаас болж цааш өрнөж байгаа шалтгаануудыг сонирхолтойгоор, логик учир зүйгээр, оновчтой холбох
- Аяллынхаа газар орон, аялсан цаг хугацаа, нөхцөл байдлаа гаргахдаа дүрслэлийг онож сонгон хэрэглэх

Алхам 2. Аяллынхаа сонин сайхныг, газар орны онцлог, аялсан цаг үеэ, нөхцөл байдлаа дүрслэлээр баяжуулж сонирхолтой болгон сайжруулж бичээрэй.

- Аялсан газар, нутаг орон, улс гүрнээс санаанд чинь хамгийн тод бууж байгаа нь аль вэ?
- Аялсан цаг үе чинь хэзээ байв, ямар онцлогтой байв?
- Хүмүүсийг гайхшруулсан, юм үзэгдэл, үйл явдал юу байв?
- Чамд таатай, таагүй санагдсан үйл явдлууд юу байв?
- Чиний ирээдүйд ямар нэгэн байдлаар нөлөө үзүүлсэн, өөрчилсөн зүйл юу байв?
- Уншигчийг энэ газарт аялсан юм шиг мэдрэмж төрүүлэхээр хэрхэн бичих вэ?

Алхам 3. Бичсэн тэмдэглэлдээ засвар хийж, сайжруулан бичээрэй.

- Эхлэл, гол, төгсгөл хэсгүүд болон өгүүлбэр цогцолборын агуулгын уялдаа холбоо зөв болсон уу?
- Сэдэвтээ тохирсон агуулгаа оновчтой гаргаж чадсан уу?
- Сэтгэгдэл мэдрэмжээ оруулан оновчтой үг хэллэгээр гарган бичиж чадсан уу?
- Дүрслэлийг оновчтой сонгон хэрэглэж чадсан уу? (миний бичсэнийг уншсан хүн сэтгэл сэргэх, уярах, баярлах, бахархах, хайрлах болон аялсан газарт очсон юм шиг сэтгэгдэл төрөхөөр болж чадсан уу)
- Зөв бичих дүрмийн хувьд алдаагүй байж чадсан уу?



Зарим нэг бүтээлч аргыг хэрэглэснээр чиний бичиж буй тэмдэглэл чинь өвөрмөц сонин содон болно. Тухайлбал, “Бүхнийг ил хэлэхгүй орхих”, “Сонирхолтой харилцан яриа оруулах” гм.

Мэдрэмж, сэтгэгдэл, үнэлэмж, үзэл бодлоо бодит зүйл, баримтад үндэслэн илэрхийлэхийн тулд:

Тухайн үед өөрт чинь юу бодогдож, сэтгэгдэж, мэдрэгдэж байгаагаа сайн анзаарч түүнийгээ бичихдээ ашиглана. Хүүхдүүд заримдаа баримт, бодит байдалтай ямар ч холбоогүй сэтгэгдэл, үзэл бодол, мэдрэмжийг илэрхийлээд байдаг. Тийм алдаа гаргахгүй байхыг хичээгээрэй.

Тэмдэглэлийн гол хэсэг чинь хэдэн ч цогцолбороос бүтэж болох ба энэ нь бичиж буй агуулгын уялдаа холбооноос шалтгаалж болно.

Бичих бүтэц.

Эхлэл: -----

Эхийн гол хэсэг


Төгсгөл-----

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



ЗНӨ бүтэх арга



Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн онцлог:

- ✓ Зэрэгцэх харьцаанд суурилах учир нэг нь нөгөөдөө захирагдахгүй
- ✓ Өгүүлэгдэхүүн нь ямагт нэрлэхийн тийн ялгалд байна.
- ✓ Өгүүлбэрүүдийн байрыг солин хувиргахад утга бүтэц өөрчлөгдөхгүй.

Даалгавар 4. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, үүрэг, хэрэглээ

Аян замын тэмдэглэлийг уншаад дасгалыг ажиллаарай.

Даваан дээрээс Отгон тэнгэрийн оргил бадамлан гялалзаж харагдана. Тэнгэрийн отгон хөвгүүн түүний бараа сүрийг аялах замд бишгүй олон харсан ч мөнөөхөн миний хүрэхийг зорин тэмүүлэн тэмүүлсээр өдий хүрсэн ганцхан уул шиг дотно санагднам. Хүнд өөрийн уул гэж байдаг бол төрсөн нутгаас минь алсын алсад орших атал, миний уул чухам энэ Отгонтэнгэр гэлтэй. Амьдралын зорилго гэгч мөнхүү амьдралын өндөр давааны оргил хэмээвээс энэ Отгонтэнгэрийн оргил шиг хүрэхүйеэ бэрх бөгөөд үргэлж даллан дуудаж, ойртохын хэрээр улам өндөр болдог ажээ. Тийм оргил үгүйсэн бол мацахын хэрэг юу билээ. Хүний замд хөндөлсөх даваа бүхэн өөрийн үүх түүх, үг хэлтэй. Угалзын зоо шиг энэ хөх халзан даваа эртний жингийн замыг мөрлөн өргөж аянчин жуулчинд Отгон тэнгэрийн оргилыг зориуд харуулах гэсэн шиг. Давааны оройн их овоонд өргөсөн юмс хүн байгаль лугаа учралдан найрсах, эсэргүүцэн тэмцэлдэх ёсыг өгүүлнэ...

/С.Эрдэнийн "АЯН ЗАМЫН БОДОЛ БУЮУ УЯНГЫН ЭРХИ"-ээс хэсэглэн авав/

Алхам 1. Эхэд байгаа “бөгөөд” хэмээх холбох үгийн утга үүргийг зөв тодорхойлоорой.

- A. Үг ба өгүүлбэрийг холбох үүрэгтэй
- B. Угсруулах утгатай, өгүүлбэрийг холбох үүрэгтэй.
- C. Төгс өгүүлбэрүүдийг зэрэгцүүлэн холбох үүрэгтэй.
- D. Өгүүлбэрийг биш үгийг холбох үүрэгтэй, зэрэгцүүлэх утгатай.

Алхам 2. Эхээс зэрэгцүүлэн холбох аргаар холбогдсон өгүүлбэрүүдийг түүн бичээрэй.

Алхам 3. Өгүүлбэрүүдийн төгс бус өгүүлэхүүн гишүүний илрэх байдлыг ажиглан, дүгнэлт гарган зөв харгалзуулаарай.

1. Зовхи нь нимгэн бөгөөд гар хуруу нь цэвэр.	a. Зэрэгцүүлэн холбох нөхцөлөөр холбогдсон
2. Туулайн гүйдэл шиг салхинд Туулын шугуй найгана Уулын согоо шиг хүүхэнд Хайрын сэтгэл дасна....	b. Зэрэгцүүлэн холбох үгээр холбогдсон.
3. Наран дээрээс гэрлээрээ гайхуулан <u>мишээхэд</u> намуун талаас би хүний дууг аялдаг юм.	c. Цагт нэрийн дагаврын араас өгөх оршихын –д нөхцөл авсан
4. Тэр хар хүний цээж нь урагш түрсхийж, судас шөрмөс нь гүрэлзэж, хатангир шилбэ нь шуумаг дороос нь цухуйжээ.	d. Хэлэх аялгаар зэрэгцсэн.

A. 1a, 2d, 3c, 4b

B. 1b, 2d, 3c, 4a

B. 1b, 2c, 3d, 4a

Алхам 4. “АЯН ЗАМЫН БОДОЛ БУЮУ УЯНГЫН ЭРХИ”- эхээс онцолсон өгүүлбэрийн холбоосыг ажиглан бүтцийг тодорхойлоорой.

- A. Энгийн дэлгэрэнгүй өгүүлбэр
- B. Угсарсан нийлмэл өгүүлбэр
- C. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр
- D. Цөм өгүүлбэр

Алхам 5. Дараах энгийн өгүүлбэрүүдийг ЗНӨ болгон бичээрэй.

/Ашиглах хэрэглүүр: -ж, -ч -н, -аад⁴ агаад, хийгээд, ба/



1. Салхи сэнгэнэв. Униар будан хүрээлнэ.

2. Орчин тойрон нам гүм. Ойрхон аргамжаатай морь хааяа тургина.

3. Өвлийн хүйтнийг адуу манаж өнгөрүүлнэ. Зуны халууныг хонь хариулж гэтэлгэнэ. Зовлонтойгоор он жилийг нөхцүүлнэ.”

Алхам 6. Дараах бодомжуудаас зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн хэв шинжид тохирохыг сонгоорой.

- A. Тодотгон холбох нөхцөлөөр хэлбэрждэг.
- B. Өгүүлбэрийн гишүүдийн байрыг солиход утга нь өөрчлөгдөхгүй.
- C. Өгүүлбэрүүдийн байрыг солиход утга нь алдагдахгүй.
- D. Өгүүлбэрүүд нэг нь нөгөөдөө захирагдана.

Алхам 7. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн үүргийг тодорхойлно уу?

- A. Үйл явдлын шалтгааныг өгүүлэх
- B. Уран сайхнаар дүрслэх
- C. Үйл явдлыг нэгэн цагт зэрэгцүүлэн тоочих
- D. Байгалийг зураглан тоочих

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



УНӨ



Угсарсан нийлмэл өгүүлбэрийн онцлог:

- Дагуул ба цөмийн харьцаанд суурилах учир цөм өгүүлбэр нь дагуул өгүүлбэрээ захирах харьцаанд суурилна. Өөрөөр хэлбэл гол өгүүлбэр нь дэлгэрүүлэгч өгүүлбэрүүдээ захирна.
- Гишүүн өгүүлбэр нь гол өгүүлбэртээ найрах ба хамжих аргаар угсарч холбогдон, гол өгүүлбэрийг орон, цаг, шалтгаан, зорилго, болзол, шинж чанар, харьяа хамаарлын утгаар нэмэн дэлгэрүүлж, аль нэг гишүүний үүрэг гүйцэтгэнэ.
- Гишүүн өгүүлбэрийг тодорхойлохдоо өгүүлэхүүн гишүүн нь ямар нөхцөлөөр хувилсан, гол өгүүлбэрийн аль гишүүнд холбогдож, гишүүн өгүүлбэр бүхэлдээ ямар асуултад хариулагдаж байгааг харгалзана. Тухайлбал: байц гишүүн нь үйлийг орон, цаг, зорилго, шалтгааны утгаар дэлгэрүүлдэг бол байц гишүүн өгүүлбэр нь мөн адил гол өгүүлбэрийн өгүүлэхүүн гишүүнийг орон, цаг, зорилго, шалтгааны утгаар дэлгэрүүлж хаана?, хэзээ?, ямар учраас? яахаар? гэх зэрэг асуултанд хариулагдаж байдаг.
- Учир шалтгааны утгатай нийлмэл өгүүлбэрийг задлан шинжлэх, шалтгааны утгаар нийлмэл өгүүлбэрийн холбон найруулах нь шалтгаан, үр дагаврын холбоо хамаарлыг гаргах, асуудал дэвшүүлэн өөрийн үзэл бодлоо илэрхийлэх зэрэгт чухал ач холбогдолтой юм.

Гишүүн өгүүлбэр	Өгүүлэхүүний хэлбэржилт
Шууд тусагдахуун ГӨ	Заахын ТЯ
Харьяалахын тодотгол ГӨ	Харьяалахын ТЯ
Шууд бус тусагдахуун ГӨ	ӨОТЯ, ГТЯ, УТЯ, ХамТЯ
Нэрийн хамжсан тодотгол ГӨ	Тодотгон холбох нөхцөлүүд
Үйлийн хамжсан тодотгол ГӨ	Үндсээрээ
Байц ГӨ	Орон-цагийн нэр, угсруулан холбох холбоос-үүгүүд, ӨОТЯ, ГТЯ, УТЯ, ЧТЯ

Алхам 1. Өгүүлбэрийг хооронд нь угсруулан холбох хэрэглүүрийг зөв тодорхойлоорой.

- A. Үйлийн цагаар төгсгөх бүлэг нөхцөл, угсруулан холбох үгс
- B. Үйлийн нөхцөлдүүлэн холбох бүх нөхцөл, угсруулан холбох бүлэг үг
- C. Тодотгон холбох нөхцөлүүд, үйлийн нөхцөлдүүлэн холбох бүх нөхцөл
- D. Үйлийн нөхцөлдүүлэн холбохын угсруулан холбох бүлэг нөхцөл, тодотгон холбох нөхцөлүүд, угсруулан холбох үгс
- E. Бүх холбох нөхцөл, холбоос үг

Алхам 2. Угсруулан холбох аргыг зөв тодорхойлоорой.

- A. Нэг өгүүлбэрийг нөгөөтэй нь зэрэгцүүлэн холбоно.
- B. Угсруулан холбох нөхцөл болон холбоос үг ашиглан дагуул цөмийн харьцаанд холбоно.
- C. Өгүүлбэрүүдийг нөхцөлөөр холбоно.
- D. Гол ба гишүүн өгүүлбэрийн харьцаанд холбоно.
- E. Холбоос үгээр холбоно.

Алхам 3. Төгс бус өгүүлэхүүний утга, үүргийг тодорхойлж тайлбарлая

“Аав ээждээ туслахаар ажил амьдралд суралцахаар алс хөдөөг зорилоо.” гэсэн өгүүлбэрийн онцолсон өгүүлэхүүн дараагийн ямар гишүүнд хэрхэн холбогдсоныг тодорхойлоорой.

- A. “суралцахаар” гэсэн төгс бус өгүүлэхүүн гишүүний шалтгааныг зааж угсарч холбогдсон.
- B. “ажилд амьдралд” гэсэн шууд тусагдахуун гишүүнд зэрэгцэж холбогдсон.
- C. “зорилоо” гэсэн төгс өгүүлэхүүний цагийг заасан байц гишүүн өгүүлбэр болж угсарч холбогдсон.
- D. “зорилоо” гэсэн гол өгүүлбэрийн өгүүлэхүүн гишүүнийг дэлгэрүүлж, зорилгыг заасан байц гишүүн өгүүлбэр болж угсарч холбогдсон.

Алхам 5. Үйлийн орон, цаг, зорилго, шалтгаан заасан өгүүлэхүүнтэй гишүүн өгүүлбэр нь:

- A. Үйлийн хамжсан тодотгол гишүүн өгүүлбэр болно.
- B. Байц гишүүн болно.
- C. Шууд бус тусагдахуун гишүүн өгүүлбэр болно.
- D. Байц гишүүн өгүүлбэр болно.
- E. Шууд тусагдахуун гишүүн өгүүлбэр болно.

Алхам 5. Доорх өгүүлбэрийн бүтцийг зөв тодорхойлоорой.

Гүү унагалах үеэр эсвэл хээрийн амьтан ширүүн болох үед манайх адуугаа манадаг байлаа.

- A. ЭӨ
- B. ЗНӨ
- C. УНӨ
- D. Бусад

Алхам 6. “Гүү унагалах үеэр эсвэл хээрийн амьтан ширүүн болох үед манайх адуугаа манадаг байлаа.” гэсэн өгүүлбэрийн онцолсон гишүүн өгүүлбэрийг зөв тодорхойлоорой.

- A. Гол өгүүлбэрийн өгүүлэхүүн гишүүнийг орны утгаар дэлгэрүүлсэн орны байц ГӨ болно.
- B. Гол өгүүлбэрийн өгүүлэхүүнийг тодотгосон учраас үйлийн хамжсан тодотгол ГӨ болно.
- C. Гол өгүүлбэрийн өгүүлэхүүнийг цагийн утгаар дэлгэрүүлсэн учраас цагийн байц ГӨ.
- D. “манайх” гэдэг үгтэй холбогдож нэрийн хамжсан тодотгол ГӨ болно.

Алхам 7. “Шар усанд дэвтсэнээс багахан хэсгийг аваад ир.”- Онцолсон гишүүн өгүүлбэрийг зөв тодорхойлоорой.

- A. Гол өгүүлбэрийн өгүүлэхүүнтэй холбогдож шалтгааны утга зааж байгаа учир байц гишүүн өгүүлбэр
- B. Өгүүлэхүүн гишүүн нь тодотгон холбох+заахын тийн ялгалаар хэлбэржиж бүхэлдээ юунаас? гэсэн асуултад хариулагдан гол өгүүлбэрийн өгүүлэхүүн гишүүнийг үйлэнд шууд бус өртөх утгаар дэлгэрүүлж байгаа тул шууд бус тусагдахуун ГӨ болно.
- C. “багахан” гэсэн үгтэй холбогдож байгаа тул нэрийн хамжсан тодотгол ГӨ болно.
- D. Угсруулах холбоо байхгүй тул гишүүн өгүүлбэр байхгүй.

Алхам 8. “ Энэ жил бороо хур арвин байна. Дэнж тэр чигээрээ ногоорон харагдана.” – гэсэн өгүүлбэрүүдийг аль холбоосоор холбон найруулбал шалтгааны утгатай байц ГӨ-тэй УНӨ бүтэх вэ?

- A. бөгөөд B. учраас C. тулд D. төлөө E. хойно

Алхам 9. “Токиогийн их сургуульд суралцана. Маргаашийн онгоцоор ниснэ.”- өгүүлбэрүүдийг тохирох бүтээврээр холбож зорилгын утга бүхий байц ГӨ-тэй УНӨ бүтээгээрэй.

- A. –ны дараа B. –магц C. –хлаар D. –х+ аар (ҮТЯ)

Алхам 10 ” Хичээлээ сайн уншаагүйгээс шалгалтандаа тааруу дүн авлаа.” Онцолсон бүтээврийг ойролцоо утгатай холбоос үгээр солин найруулаарай.

- A. учраас B. буюу C. үед D. тулд E. маргааш

Алхам 11. Дараах бодомжуудаас угсарсан нийлмэл өгүүлбэрийн хэв шинжид тохирохыг сонгоорой.

- A. Зэрэгцүүлэх нөхцөлөөр хэлбэрждэг.
- B. Нэг өгүүлбэр нь нөгөөдөө захирагдаж, дагуул ба цөмийн харьцаанд суурилдаг.
- C. Өгүүлбэрийн гишүүдийн байрыг солиход утга нь өөрчлөгдөхгүй.
- D. Өгүүлбэрүүдийн байрыг солиход утга нь алдагдахгүй
- E. Өгүүлбэрүүд нэг нь нөгөөдөө захирагдахгүй.

Алхам 12 Үйлийг шалтгааны утгаар дэлгэрүүлсэн /нэг үйл нь нөгөөгийнхөө урган гарах шалтгаан болсон/ өгүүлбэр зохион бичээрэй.

Алхам 13 Аян замын тэмдэглэл бичихэд дараах өгүүлбэрүүдээс аль илүү их хэрэглэгдэх бол?

- A. Шалтгааны утгатай байц ГӨ-тэй УНӨ
- B. Орны утгатай байц ГӨ-тэй УНӨ
- C. Зорилгын утгатай байц ГӨ-тэй УНӨ
- D. Цагийн утгатай байц ГӨ-тэй УНӨ

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Эрдэм шинжилгээний хялбаршуулсан эх гэдэг нь: Ямар нэгэн

шинжлэх ухааны ухагдахууныг бүхий л хүн ойлгохоор энгийн аргаар тайлбарласан байдаг онцлогтой. Өөрөөр хэлбэл тухайн ухагдахуун, үзэгдэл, томъёоллыг энгийн бодит жишээ болгон хэн хүний хялбар ухаарах зүйлтэй адилтган найруулдаг байна. Найруулгын энэ төрөлд шинжлэх ухааны ойлголтуудыг энгийн хялбар аргаар тайлбарласан сурах бичиг, ном товхимол, өгүүлэл, лекц зэрэг орно. Шинжлэх ухааны эхийн гол үүрэг нь дэвшүүлсэн таамаглалынхаа үнэнийг батлахад орших бөгөөд мэдээлэх, нөлөөлөх зорилготой байдаг. Иймээс учир шалтгааны нарийн дараалалтай, тодорхой, оновчтой, баталгаа нотолгоо сайтай байж гэмээн зорилгоо биелүүлдэг байна.

Учир шалтгааны дараалал: Бичиж буй зүйл нарийн дэс дараалалтай байж, хоорондоо утгын нягт уялдаатай байна. Өөрөөр хэлбэл, ухагдахуун нь тодорхой, үндэслэл сайтай байх зарчимд суурилна гэсэн үг юм.

Тодорхой байх: Нийт уншигчдад маш ойлгомжтой, хялбах, энгийн байдлаар бичиж найруулах шаардлагатай.


Оновчтой байх: Илэрхийлэх гэсэн санаагаа цөөн үгээр онож өгүүлэх юм.

Мэргэжлийн үг хэллэг нь: Тодорхой нэг мэргэжлийн хүмүүсийн дунд ойлгогдох зонхилон нэр томъёоны чанартай үг хэллэг байна.

Нэр томъёо: Үгийн сангийн нэлээд боловсорсон хэсэг бөгөөд соёл урлаг, улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн салбарт тогтмол хэрэглэх ухагдахуун илтгэсэн, тухайн салбартаа ганц утгыг илтгэх, зориуд зохион боловсруулсан нэрийтгэл үгийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, тодорхой салбарын ухагдахууныг тэмдэглэдэг, мэргэжлийн хүрээнд тусгайлан тогтоосон үгс. Жишээлбэл: Монгол хэлний нэр томъёонд: өгүүлбэр, цэг, үг, авиа, үсэг, эх, цогцолбор гэх мэт орно. Нэр томъёо энгийн үг хоёр хэлбэрийн хувьд адил боловч гүйцэтгэх үүрэг хэрэглээгээрээ ялгаатай байдаг. Тодорхой шинжлэх ухааны утга агуулга илэрхийлж байвал нэр томъёоны үүрэгтэй болж, энэ үүрэг нь алдагдвал энгийн үг болох нь бий. Жишээ нь: “Би ууланд явлаа” гэсэн өгүүлбэрт “уул” гэдэг үг нь жирийн утгаар орсон бол харин газарзүйн шинжлэх ухаанд “уул” гэсэн үгийг ашиглавал тэр нь нэр томъёоны үүргээр хэрэглэгдэнэ.



Үүнээс гадна эрдэм шинжилгээний хялбаршуулсан эх нь тодотгол, тайлбар, жишээ ихтэй байдаг аж



Хэл зүйн
онцлог

Үйл үгийг голдуу одоо цагийн хэлбэрээр бичих бөгөөд , нэгдүгээр биеийн төлөөний үгийг ашиглан бичих нь их бий.

Нэр үг, тэмдэг нэр, үйл үг их хэрэглэдэг байна.

Зэрэгцсэн гишүүнтэй энгийн, хүүрнэх өгүүлбэр болон оруулсан үг хэрэглэх нь их байдаг.

Догол мөрийн үүрэг хэрэглээ их бий.

Мөн харилцан ярианы хэлбэрийг ч ашиглан бичдэг байна.

Даалгавар 6. Шинжлэх ухааны хялбаршуулсан эхийг уншиж ойлгох

Эхийг уншиж ойлгоод, дасгалыг ажиллаарай.

Дэлхий хэмээх энэ агуу том бөмбөрцөг мөхөл рүүгээ цаг минутаар урагшилж байна. Эрдэмтэн судлаачид ийм дүгнэлтэд хүрч, өдөр тутмын аар саархан зүйлийн араас хөөцөлдөн хоногийн бор хоолоо бодон амьдарч буй хүмүүсээс илүүтэй санаа зовних болов. Манай гараг түүхэндээ бишгүй олон осол гамшигтай учирч, амьтан бүхэн устан үгүйрч байлаа. Дэлхийн сүйрлийн тухай домог үлгэрүүд олон зууныг дамжин өртөөлсөөр бидэнд өвлөгдөн үлджээ. Ялангуяа хамгийн аймшигт сүйрлийн үеэр устсан дөрөв дэх соёл иргэншлийн талаар маш олон баримт нотолгоо ар араасаа хөврөн гарсаар л байна. Атлантид гүрний мөхөл бол тэдгээр соёл иргэншилт нийгмийн тод жишээ юм. Эрдэмтэд дэлхийг сүйрүүлэх долоон шалтгааныг нэрлэж байна.

Соронзон туйл өөрчлөгдвөл...

Өнгөрсөн зургаан тэрбум жилийн хугацаанд дэлхийн соронзон туйл байрлалаа хэдэн зуун удаа өөрчилснөөс болж уур амьсгал нь огцом хувирч байжээ. Тухайлбал: 12 мянган жилийн өмнө дэлхий мөсөнд хучигдан үй олон амьтад үхэж үрэгджээ. Үүнийг геофизикчид туйлын байрлал өөрчлөгдсөнтэй холбон тайлбарладаг.

Тэд туйлын “суудал”-аа өөрчилсөн газраас 2000 км орчим яваад буцаж ирэхдээ энэхүү дүгнэлтийг гаргасан байна. Соронзон туйл эдүгээ өөрчлөгдөх замдаа аль эрт шуудран орчихоод байгаа аж. Америкийн цэрэг, техникийн их сургуулийн тооцоолсноор, дэлхийн хойд соронзон туйл өнгөрсөн арван жилийн хугацаанд хэдэн зуун метрээр өөрчлөгджээ. Магадгүй хамгийн сүүлийн, хамгийн томоохон “нүүдэл” энэ зууны төгсгөлд болж мэдэхээр байна.

“Тэр үед хүн төрөлхтөн болоод ан амьтан, хөвч ой, ургамал ногооны дийлэнх хэсэг нь устана” хэмээн Шмидтийн нэрэмжит дэлхийн физик судлалийн төвийн орлогч захирал Алексей Диденко ярьжээ.

Гэхдээ түүний үгээр бол туйлын энэхүү өөрчлөлтийн улмаас соронзон талбайн хэмжээ багасан, дэлхийн гадаргуу нарны хэт цацрагийн хорт нөлөөнөөс хамгаалагдах талтай гэнэ.

Г.Идэрхангай “Дэлхийн төгсгөлийн 7 шалтгаан” өгүүллээс хэсэглэж авав.


Алхам 1 Эхийг уншаад агуулгыг хэдэн хэсэгт яаж хувааж болох вэ?

- Тайлбар ба жишээ гэсэн хоёр хэсэгт
- Бүхэл ба хэсэг гэсэн хоёр хэсэгт
- Мөн чанар ба дүгнэлт гэсэн хоёр хэсэгт
- Ерөнхий ба тодорхой гэсэн хоёр хэсэгт
- Тайлбар ба тодорхойлолт гэсэн хоёр хэсэгт

Алхам 2 “Дэлхий хэмээх энэ агуу том бөмбөрцөг мөхөл рүүгээ цаг минутаар урагшилж байна” гэсэн санаагаа ямар баримтуудаар баталсныг олоорой /Хэдэн ч баримт сонгож болно, зөв хариултаа өмнө нь ✓ гэж тэмдэглээрэй.

- A. Үүнийг геофизикчид туйлын байрлал өөрчлөгдсөнтэй холбон тайлбарладаг.
- B. Дэлхийн хойд соронзон туйл өнгөрсөн арван жилийн хугацаанд хэдэн зуун метрээр өөрчлөгджээ.
- C. Эрдэмтэд дэлхийг сүйрүүлэх долоон шалтгааныг нэрлэж байна.
- D. Тэр үед хүн төрөлхтөн болоод ан амьтан, хөвч ой, ургамал ногооны дийлэнх хэсэг нь устана” хэмээн Алексей Диденко ярьжээ.
- E. Магадгүй хамгийн сүүлийн, хамгийн томоохон “нүүдэл” энэ зууны төгсгөлд болж мэдэхээр байна.
- F. 12 мянган жилийн өмнө дэлхий мөсөнд хучигдан үй олон амьтад үхэж үрэгджээ.
- G. Дэлхийн гадаргуу нарны хэт цацрагийн хорт нөлөөнөөс хамгаалагдах талтай

Алхам 3. а. Өгүүлбэрүүдийг учир шалтгааны зөв дараалалд оруулж байрлуулаарай.



- A. Дэлхийн соронзон туйл байрлалаа хэдэн зуун удаа өөрчилснөөс болж уур амьсгал нь огцом хувирч байжээ.
- B. Соронзон туйл эдүгээ өөрчлөгдөх замдаа аль эрт шуудран орчихоод байгаа аж.
- C. Эрдэмтэн судлаачид санаа зовних болов.
- D. Энэ агуу том бөмбөрцөг мөхөл рүүгээ цаг минутаар урагшилж байна.
- E. Ялангуяа хамгийн аймшигт сүйрлийн үеэр устсан дөрөв дэх соёл иргэншлийн талаар маш олон баримт нотолгоо ар араасаа хөврөн гарсаар л байна.

б. Юунд үндэслэж дараалалд оруулснаа тайлбарлан бичээрэй.

Алхам 4 Эхэд орсон нийлмэл үгсийн дарааллыг ажиглаад, цэгийн оронд тохирохыг нь олоорой.

Аар саархан, соронзон туйл, осол гамшиг, дэлхийн гадаргуу, ан амьтан, ...

- A. соронзон талбай
- B. баримт нотолгоо
- C. санаа зовних
- D. буцаж ирэх
- E. хүн төрөлхтөн

Алхам 5 Дээрх 4-р даалгаварт байгаа дараалалд ямар үг хэллэг нөхөж бичсэн бэ? Үүнээс эхэд хэрэглэсэн үг хэллэгийн онцлогийг дүгнээрэй.

Алхам 6 Эхэд ашигласан нэр томъёоны үг нь аль вэ?

- A. соёл иргэншил
- B. цэргийн сургууль
- C. физик судлал
- D. хорт нөлөө
- E. дэлхийн сүйрэл

Алхам 7 Эдгээрээс эхэд ороогүй нь аль вэ? /1-ээс дээш хариу сонгоно. Эхэд орсныг нь “+” гэж, ороогүйг өмнө нь “х” гэж өмнө нь тэмдэглээрэй.

мэргэжлийн үг хэллэг	баримт
нэр томъёо	тайлбар
мэдрэмж сэтгэгдэл	дүгнэлт
нийлмэл үг	үзэл бодол
уран дүрслэл	тодорхойлолт

3. Өгүүлбэрт онцолсон бүтээврийг солин найруулахад тохирохыг сонгоорой.
Анимаагийн гунигаар өвс бүхэн шаргалтаж, гол ус зайрмагтан, тунгалаг сэтгэлийн нулимс адил жирэлзэн урсаж, нимгэн мөсөн доогуур мэлмэрнэ.

A. –ж, B. –на C. –маар D. –сан

4. “Агаад, хийгээд, буюу, бөгөөд” зэрэг бүтээврүүдийн утга, үүргийг тайлбарлаарай.

- A. Угсруулан холбох
- B. Зэрэгцүүлэн холбох
- C. Шалтгааны утгаар холбох
- D. Цагийн утгаар холбох

5. “Хөөрхий Анимааг санаа алдахад Гурван маралын зүг сэв сэв салхилна.”- гэсэн өгүүлбэрийн бүтцийг тодорхойлоорой.

- A. Цагийн байц ГӨ-тэй УНӨ
- B. Орны байц ГӨ-тэй УНӨ
- C. Шууд бус тусагдахуун ГӨ-тэй УНӨ
- D. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр

6. “Сувд шиг гялталзсан өнгөтэй хавчаар бэлэглэжээ.”-Өгүүлбэрийн ГиӨ-ийн үүргийг тайлбарлаарай.

- A. Энгийн өгүүлбэр учраас ГӨ байхгүй.
- B. “өнгөтэй” гэсэн тэмдэг нэрийг дэлгэрүүлэх үүрэгтэй
- C. “бэлэглэжээ” гэсэн үгийг дүр байдлын утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
- D. “Сувд шиг” гэдэг үгийг тодруулах үүрэгтэй.

7. “Сувд шиг гялталзсан өнгөтэй хавчаар бэлэглэжээ.”-Өгүүлбэрийн ГиӨ-ийг зөв тодорхойлоорой.

- A. шууд бус тусагдахуун гишүүн өгүүлбэр
- B. нэрийн хамжсан тодотгол гишүүн өгүүлбэр
- C. байц гишүүн өгүүлбэр
- D. “Сувд шиг” гэдэг үгийг тодруулах үүрэгтэй тул ГӨ болохгүй.

8. “Хөөрхий Анимааг санаа алдахад Гурван маралын зүг сэв сэв салхилна.”- Өгүүлбэрийн онцолсон бүтээврийг солин найруулахад тохирох холбоос үгийг сонгоорой.

A. тул B. учраас C. үеэр D. буюу

9. Шинжлэх ухааны хялбаршуулсан эхийн онцлогт тохирох хариултуудыг сонгоорой.

- A. Уран дүрслэл хааяа хэрэглэдэг.
- B. Уран дүрслэл хэрэглэдэггүй.
- C. Үгийг шилжсэн утгаар сонгож болдог
- D. Үгийг шилжсэн утгаар нь сонгож болдоггүй.
- E. Хүснэгт, заавар, эшлэл, зүүлт ашигладаггүй.
- F. Хүснэгт, заавар, эшлэл зүүлт ашигладаг.

10. Шинжлэх ухааны хялбаршуулсан эх нь найруулгын ямар төрөлд хамаарах вэ?

- A. Сонин нийтлэлийн найруулга
- B. Эрдэм шинжилгээний найруулга
- C. Уран зохиолын найруулга
- D. Албан бичгийн найруулга

11. Цэгийн оронд тохирох нь аль вэ?

Тодорхой нэг мэргэжлийн хүмүүсийн дунд ойлгогдох зонхилон нэр томьёоны чанартай үг хэллэгийг гэнэ.

- A. нэр томьёо
- B. мэргэжлийн үг хэллэг
- C. гадаад үг
- D. нийлмэл үг

12. Дараах үгсийн зөв харгалзуулаарай.

A	мэргэжлийн үг хэллэг	1	хувилгаан үүл
B	нэр томьёо	2	соронзон туйл
C	гадаад үг	3	үхэр хулгана
D	нийлмэл үг	4	хэл шинжлэл
E	уран дүрслэл	5	техник технологи

13. Эрдэм шинжилгээний эхэд дараах үгийн аймгаас алиныг нь хэрэглэх вэ?

- A. Жинхэнэ нэр, тэмдэг нэр, үйл үг голлон хэрэглэнэ
- B. Дүрслэх, дуурайх үг ихэвчлэн хэрэглэнэ.
- C. Орон цагийн нэр, төлөөний үг голлон хэрэглэнэ.
- D. Зөвхөн үйл үгийг голлон хэрэглэнэ.

14. Дараах хэсгийг уншаад аль нь болохыг сонгоорой.

“Тэр үед хүн төрөлхтөн болоод ан амьтан, хөвч ой, ургамал ногооны дийлэнх хэсэг нь устана” хэмээн Шмидтийн нэрэмжит дэлхийн физик судлалийн төвийн орлогч захирал Алексей Диденко ярьжээ

- A. дүгнэлт
- B. мэдрэмж
- C. баримт
- D. үзэл бодол

15. Цэгийн оронд тохирох үгийг олоорой.

Эрдэм шинжилгээний хялбаршуулсан эх нь, тодорхой, оновчтой, баталгаа нотолгоо сайтай байна.

- A. Мэргэжлийн үг бараг хэрэглээгүй
- B. Уран дүрслэлийг жишээ ихтэй
- C. Зохиогчийн мэдрэмж сэтгэгдэлтэй
- D. Учир шалтгааны дараалалтай

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Эргэцүүлсэн эсээ: Өгүүлэгч аливаа юмс, үйл ба хэрэг явдлын асуудал дэвшүүлж, түүнийгээ баталж нотлон дүгнэлт гаргасан байдаг.

Эргэцүүлсэн эсээнд ихэвчлэн хувь хүний өөрийн туршлага, үзэж туулсан амьдралын тухай хүүрнэн өгүүлж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлнэ. Тайлбарласан эсээтэй адил хатуу баримт нотолгоо шаардахгүй, чөлөөтэй өгүүлдгээрээ онцлог юм.

Жишээлбэл: Л.Түдэв “Үнэр идэгч” эсээг эхлэл хэсэгт эрт дивангарын үед үнэр идэгч амьтан байсан тухай анхаарал татсан шинэ содон мэдээллийн талаарх бодол эргэцүүлэлдээ тулгуурлан анх амаараа биш хамраараа ярьдаг байсан талаар урьд өмнө нь огт сонсож байгаагүй өвөрмөц санаа бүхий асуудал дэвшүүлжээ. Үүнд:

Үнэр идэгч хэмээх амьтан байсан тухай хуучны домог уншаад гайхлаа. Үнэр идэгч гэгч нь утгагүй юм шиг бодогдоно. Үнэрийг зөвхөн үнэрлэж болохоос идэж болохгүй нь лав. Тэгэхээр эцэг дээдэс юугаа ярьж байсан юм бол оо? “Үнэр идэгч дусаан хоёр төрж дээд орныг эзэгнэв” гэж ном сударт гарна. Хүн эхлээд үнэрээр ертөнцийг танин мэджээ. Бас хүнийг хүн болгосон гол эрхтэн нь хамар ажээ. Тэрчлэн хүн анхандаа амаараа биш, хамраараа ярьдаг байжээ. Энэ бүхэнд одоогийн хүмүүс итгэхгүй нь лав. Гэхдээ л худал биш үнэн болох нь нэгэнт нотлогдсон юмыг энд ярих ёстой.

Анхаарал татсан мэдээлэл:

Үнэр идэгч хэмээх амьтан байсан тухай хуучны домог уншаад гайхлаа. “Үнэр идэгч дусаан хоёр төрж дээд орныг эзэгнэв” гэж ном сударт гарна.



Үнэр идэгч гэж амьтан байсан тухай бодол эргэцүүлэл

Даалгавар 1 Эргэцүүлсэн эсээний эхлэл хэсгийг уншиж ойлгох

Алхам 1. Эсээ тус бүрийн эхлэл хэсгийг уншаад, уншигчдын анхаарал татсан хэсгийг олж, өнгөөр ялган тэмдэглээрэй.

Алхам 2. Ялгаж тэмдэглэсэн хэсэгт ямар сонин содон мэдээлэл байгааг бичээрэй.

1 Д.Урианхай Тэнцэтгэл

Амьдралыг би ямагт тэнцэтгэл гэж бодно. Тэнцэтгэлийн нэг тал нь “Агуу их “Амьдрал” өөрөө байж таарна. Нөгөө тал нь “Хайрлах”-ын сайхан дээр “хийх”-ийн сайхныг нэмж байж таарах байх. Хийх”-ийн сайхан дээр ямар нэг дайвар нэмэгдэж таарах байх. Харин тэр дайвар юу байх вэ? Энэ бол надад үл мэдэгдэгч.

.....

.....

.....

.....

.....

2 Л.Түдэв Үхэр хулгана

“Хэрэв хулгана хорин килограмм татахаар жинтэй байсан сан бол хүн яагаад ч дэлхийн эзэн болж чадахгүй сэн дээ” гэж суут эрдэмтэн Эйнштейн хэлжээ. Дэлхийн шинжлэх ухаан, хүн төрөлхтний оюуны соёл иргэншлийн түүхэнд бүхэл бүтэн үеийн эзлэх гайхамшигтай нээлт хийсэн тэр суут эрдэмтэн яагаад ингэж хэлсэн юм бол оо гэдгийг эргэцүүлэн бодож их л гайхдаг үе надад байлаа. Дэлхийг хэд дахин устгаж чадах халуун цөмийн тухай тэр мэдэж байсан болохоор хулгана зэргийг юухнаар ч устгаж орхино гэдгийг төсөөлөхгүй байв гэж үү дээ?

.....

.....

.....

.....

.....

Орчлонгийн түг түмэн юмс дунд цэцэг гэж нэг эрхэм сайхан зүйл байдаг. Цэцэг ургадаггүй орон, газар, арал хойг ертөнцөд үгүй. Цаст уулын цармыг ч, мөсөнтуйлын хормойг ч цэцэг л чимж байдаг. Орой намрын жихүүн салхи, дүн өвлийн хөр цас ч цэцэг ургахыг хорьж чаддаггүй. Цэцгийг ургамлын аймагт багтаадаг ч цэцгийг ургамал гэж хэлэх нь ухаан санаанд багтамгүй санагддаг. Цэцэг бол ургамлаас ч өөр, амьтдаас ч өөр...

Даалгавар 2 Эсээний хөтөч санаа, дэвшүүлсэн асуудлыг олж тайлбарлах



Дэвшүүлсэн асуудал, хөтөч санаа: Асуудал гэдэг нь одоогийн бодит байдал, зохиогчийн хүрэхийг хүсэж буй зорилго хоёрын хооронд үүсэж буй нөхцөл байдал бол эсээний сэдэв (дэвшүүлсэн асуудал), гол санааны хураангуй илэрхийлэл нь хөтөч санаа юм. Иймээс эсээнд дэвшүүлсэн асуудлыг олохыг тулд эсээний хөтөч санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олно гэсэн үг.

Хөтөч санаа нь сэдэв гол санааг нэгээс хоёр өгүүлбэрт төвлөрүүлэн илэрхийлдэг. Ингэхдээ зөвхөн дэвшүүлсэн асуудлыг илтгэхээс гадна уг сэдвийн талаарх зохиогчийн байр суурийг ч мөн илэрхийлж байдаг. Өөрөөр хэлбэл уг эсээнд юуны тухай өгүүлэхийг хэлэхийн зэрэгцээ эсээг бичихэд хөтлөн чиглүүлэх үүрэгтэй байна. Хөтөч санааг илэрхийлсэн өгүүлбэр нь дэвшүүлсэн асуудал, гол санааг багтааж байдаг тул тухайн өгүүлбэрээс асуудлыг олж болно. Жишээлбэл: “Үнэр идэгч” эсээний хөтөч өгүүлбэрт зохиогч хамраар ярьдаг байсан тухай чухалчилжээ. Үүнээс асуудлыг олбол:

Хөтөч санаа

Тэрчлэн хүн анхандаа амаараа биш, хамраараа ярьдаг байжээ.

Хүн анх хамраараа ярьдаг байсан тухай

Дэвшүүлсэн асуудал

Хамраар ярьдаг байсан

Алхам 1. Эсээ тус бүрийн эхлэл хэсгээс хөтөч санаа бүхий өгүүлбэрүүдийг олоод, харгалзах нүдэнд гэж тэмдэглээрэй.

Д.Батбаяр
“Хайр
сэтгэл”

- а) Цэцгийг ургамлын аймагт багтаадаг ч цэцгийг ургамал гэж хэлэх нь ухаан санаанд багтамгүй санагддаг
- б) Орой намрын жихүүн салхи, дүн өвлийн хөр цас ч цэцэг ургахыг хорьж чаддаггүй..
- в) Цэцэг шиг энхрий ялдам, эмзэг турьхан юм орчлонд зөвхөн хайр сэтгэл л байдаг.

Д.Урианхай
"Тэнцэтгэл"

- a) Амьдралыг би ямагт тэнцэтгэл гэж бодно. Тэнцэтгэлийн нэг тал нь "Агуу их "Амьдрал" өөрөө байж таарна.
b) Нөгөө тал нь "Хайрлах"-ын сайхан дээр "хийх"-ийн сайхныг нэмж байж таарах байх.
c) Харин тэр дайвар юу байх вэ? Энэ бол надад үл мэдэгдэгч.

Л.Түдэв
"Үхэр
хулгана"

- a) Эйнштейний хэлснээр үхэр хулгана хорьхон килограмм жинтэй байсан бол үнэхээр хүн төрөлхтөнд дийлдэхгүй амьтан байх байжээ.
b) Энэ тухай 16-р жарны хулгана жил буюу 1985 онд тал бүрээс эргэцүүлэн бодоод, эрдэмтэд арга буюу санал нийлжээ.
c) Хулганыг юугаар нь тийм аюултай хөнөөлтэй амьтад гэж их эрдэмтэн тооцсон юм бол?

Алхам 2 Дээрх даалгаварт байгаа хөтөч санааг илэрхийлсэн өгүүлбэрүүдийг дахин уншаад, эсээнд дэвшүүлсэн асуудлыг олж бичээрэй

Дэвшүүлсэн асуудал

Тэнцэтгэл

.....

Хайр сэтгэл

.....

Үхэр хулгана

.....

Алхам 3 Д.Батбаяр "Хайр сэтгэл" эсээнд хайр сэтгэлийг юу гэж үзсэнийг нөхөж бичээрэй.

Зохиогч "Цэцэг шиг энхрий ялдам, эмзэг турьхан юм орчлонд зөвхөн хайр сэтгэл л байдаг." гэсэн өгүүлбэртээ хайр сэтгэлийг-тэй адил, гэсэн санааг илэрхийлжээ.

Даалгавар 3 Эсээний гол ба төгсгөлийн хэсгийг тайлбарлах



Эргэцүүлсэн эсээний гол хэсэгт дэвшүүлсэн асуудлаа баталж нотолж бичихдээ асуудалд шударга голч байдлаар хандан, хоёр талаас нь авч үзэх, эсрэг үндэслэл болон бусад үзэл бодлоос үнэ цэнтэйг авч үзэн, харьцуулах арга замаар өөрийн санаа үзэл бодлыг илтгэдэг. Өөрөөр хэлбэл асуудлыг олон талаас нь эргэцүүлэн дүгнэнэ. Жишээлбэл: Л.Түдэв "Үнэр идэгч" эсээ

Ам, хамрын
үүрэг



Юмс үзэгдлийн
учир зүй зөрчилдөх

Яагаад?



"Үнэр
идэгч"
эсээнд

Аливаа юмсын ижил төстэй болон ялгаатай талыг харьцуулан, бичиж байгаа зүйлийнхээ утга агуулга, мөн чанарыг тодруулдаг. Дэвшүүлсэн асуудлаа баталж нотолж бичихдээ хэрхэн харьцуулж бичсэнийг хараарай. Аль нь давамгайлж байна вэ?

Үнэр идэгч эсээнд дэвшүүлсэн асуудлаа хэрхэн харьцуулсныг эндээс хараарай.

- | | | |
|---|--|--|
| <ul style="list-style-type: none"> ➢ Нохой агаарт 9000-хан молекул үнэр байхад мэдэрч чадна ➢ Хаана хоол унд, аюул байгааг ялгана ➢ Эх нь үрээ үнэрээр танина ➢ Садан төрөл, омог, сүргээ үнэрээр ялгаж олно. | | <ul style="list-style-type: none"> ➢ Хүний үнэрээр мэдрэх чадвар нохойноос 800 мянга дахин бага болсон ➢ Хамар үнэр ялгах авьяасаа зөвхөн арын алба болгожээ ➢ Нялх үр нь эхээ үнэрээр нь танина ➢ Хүн-үнэрийн хэлнээ түшиглэн амьтдыг сургах болсон байна |
|---|--|--|

Эрт дээр үед

(босоо явж сураагүй байх үед)

- Үнэр сайн ялгадаг
- Үнэрээр ертөнцийг танин мэддэг
- Мэдээллийн 80%-ийг хамраар авдаг
- Хамар нь нүд чихнээс илүү чухал мэдээлэл сэрэл өгдөг байжээ

Хүн- Хүн

Одоо цагт

(босоож хоёр хөл дээрээ явдаг болсон үед)

- Хоёр гуравхан үнэр ялгадаг болсон
- Хамрын үнэрлэх чадвар суларсан
- Хамгийн ашиг багатай нь хамар
- Зөвхөн үнэрлэх, амьсгалах

1. Амьдрал гэгч жингийн цуваа. Хэтэрхий хурдан явбал урдахынхаа өсгий дээр гишгэж хилэнг нь хүргэнэ. Хэтэрхий удаан явбал арын хүн өсгий дээр чинь гишгэж чиний хилэнг хөдөлгөнө.

Д.Батбаяр “Гишгэдэл”

2. Нэг талаас хайрлахын сайхан, “хийх”-ийн сайхан гээд хоёр сайхан нийлж байгаа болохоор нөгөө талаас нь муухай нийлж таарах болов уу? гэж бодогдоно. Тийн ахул тэр хоёр “муухай”-г би хамгийн сайхнаар бодоод, “хэцүү гэж оноон таамаглаж байна. Д.Урианхай “Тэнцэтгэл” эсээ” үндсэн хэсэг

хурдан явбал

 чиний хилэнг хөдөлгөнө.

.....

Алхам 2 Алхам 1 хийсэн даалгавар “Үнэр идэгч” эсээний харьцууллаас ямар ялгаатай байгааг тайлбарлаарай.

.....

Алхам 3 Д.Батбаяр “Хайр сэтгэл” эсээний гол хэсгийг уншаад хүснэгтийн дагуу харьцууллыг олж бичээрэй.

Цэцэг бол хайрлаж яваа хүмүүст зориулсан бурхны хишиг. Өөр юунд ч зориулагдаагүй. Тийм учраас хайр сэтгэлийн өнгийг дагаж цагаан, ягаан, цэнхэр өнгөөр алаглан найгаж байдаг. “Тал нутагт минь байдаггүй болоод ч тэр үү, орчлонд хар өнгийн цэцэг байдаггүй байх гэж би боддог. Хайр сэтгэлд хар өнгө байдаггүй юм чинь хар цэцэг яаж ч байх билээ дээ хэмээн бодогддог. Цэцгийн дэлбээ нээгдэх цаг гэж ертөнцөд нэгэн гайхамшигт эгшин бий. Тэр эгшин бол ертөнцийн хүмүүний аз жаргалын агшин юм. Алтан нарны гэрэлд ч юм уу, мөнгөн сарны мэлмэрэнд ч юм уу нэгэн анир амгалан мөчид цэцэг цоморлогоо дэлгэн орчин тойрныгоо өгүүлшгүй тансаг гэрэл гэгээгээр гийгүүлдэг. Цэцгийн энэ өгүүлшгүй тансаг гэрэл гэгээнд хүн хайраа олж хараад бие биесийг анир чимээгүй ширтдэг. Дурлалыг үгээр илэрхийлж болдоггүй. Хайр сэтгэлийг төгс илэрхийлэх үг аль ч хэлэнд байдаггүй

“Хайр сэтгэлийг зөвхөн цэцгийн хэлээр л төгс илэрхийлж болдог. Хайрлаж дурлаж үзээгүй хүн тэр хэлийг эс мэднэ. Цэцгийн энэ нууж хэлийг мартахаараа хүн хайрлаж дурлаж чадахаа больдог. Цэцгэнд хандаж буйгаар нь энэ бүхэн илэрнэ. Зарим хүн цэцэг гишгэчих вий хэмээн цэрвэж явдаг байхад зарим нь сайхан цэцэг хармагц дуу алдан ухасхийн тасдаж авч энгэртээ хатгахыг боддог.

Хөтөч санаа: “Хайр сэтгэл гэдэг энхрий ялдам, эмзэг турьхан цэцэг шиг “

➤ Гадаад байдал:



➤ Дотоод мөн чанар:

➤ Орчин тойрондоо нөлөөлөх нь:

Алхам 4 Цэцэг, хайр сэтгэл хоёрт хүмүүсийн хандаж буй байдлыг хэрхэн харьцуулан дүрсэлсэн байна вэ?



Алхам 5 Хайр сэтгэлийг илэрхийлэх төгс хэлийг юу гэж үзсэн бэ?

- A. Хайр сэтгэлийг илэрхийлэх хэл байхгүй
- B. Хайр сэтгэлийг илэрхийлэх хэлийг хүмүүс эс мэднэ.
- C. Ертөнцийн хүмүүний аз жаргалтай агшин юм
- D. Хайр сэтгэлийг зөвхөн цэцгийн хэлээр л төгс илэрхийлж болдог

Алхам 6 “Хайр сэтгэл” эсээний үндсэн хэсгийн дараагийн цогцолборыг уншаад, асуултын дагуу хариулж бичээрэй.

Цэцэг хайр сэтгэл хоёр шиг эмзэг юм ховор. Хэдий чинээ их дурлана төдий чинээ эмзэг хайр сэтгэлтэй учирна. Энэ л учраас цэцгийг үнсэж, илбэж таалж болдоггүй. Цэцэг тарих болсноор хүн төрөлхтөн олон зууныг элээжээ. Тийм цэцгийг таримал цэцэг буюу хүлэмжийн цэцэг гэдэг. Тэр бол харин гоёл чимэглэлд зориулсан ургамал. Түүнд бусдын нүд булаах өнгө буй ч хээрийн онгон цэцгээс өөр. Тэр бол бурхны хишиг бус. Бусдын хишиг. Хайр сэтгэл түүнтэй төсгүй. Жинхэнэ хайр сэтгэл бол атар онгон хээрийн цэцэг шиг байдаг. Түүнийг гэрийн тэжээмэл амьтан шиг гаршуулж өөрийн хэрэгт зүтгүүлж болдоггүй.

а. Юуны тухай өгүүлэв?



б. Юуг юутай харьцуулсан бэ?



в. Яаж харьцуулсныг гүйцээж бичээрэй.



цэцэг

Гоёл чимэглэлд
зориулсан

.....

Арчилж ургуулж
тордоно



цэцэг

.....

Бурхны хишиг

.....

Алхам 7 Цэцэг хайр сэтгэл хоёрыг харьцуулснаар юуг чухалчилж харуулахыг зорьсон бэ?



Алхам 8 Эсээний төгсгөл хэсгээс дүгнэлт өгүүлбэрийг олоорой.

- A. Алив юм төрсөн үүссэн эх язгууртай байдаг.
- B. Хайр сэтгэл цэцэг хоёроос орчлонгийн сайн сайхан ундарч, амьдралын хатуу хөтүүг зөөллөж өгдөг биз.
- C. Ертөнцийг цэцэггүйгээр, амьдралыг хайр сэтгэлгүйгээр төсөөлөх аргагүйн учир үүнд буй.
- D. Хэдийбээр орчлонгийн жам ёсыг даган цэцэг ургаж унаж байдаг ч цэцгийн язгуур мөхдөггүй.
- E. Орчлон энэ хоёроос ондоо гэгээн ариун эрхэм тансаг нь үгүй.

Даалгавар 4 Зохиогчийн дүгнэлт, баталгаа нотолгоог үзэл бодолтойгоо харьцуулж дүгнэх



Зохиогч эсээнд дэвшүүлсэн асуудлаа олон талаас нь эргэцүүлэн, баримт нотолгоонд тулгуурлан үзэл бодол, дүгнэлтээ илэрхийлж бичсэн байдаг.

Үзэл бодол: Баримт сэтгэгдэл хоёрын завсарт орших бөгөөд мэдлэг, мэдээлэлд тулгуурлан оюун дүгнэлт хийхийг хэлнэ. Тодруулбал, үзэл бодлыг хүний итгэл үнэмшил, ойлголт, онцгой мэдрэмж, үнэлэмж зэргийн үр дүн гэж ойлгож болно.

Дүгнэлт: Үйл явдал, үйл явц, асуудлын үр дүн, үндэслэлтэй гаргасан шийдвэр

Баримт: Цааснаа буулгаж үлдээсэн бичиг, үйл хэргийн тэмдэглэл, бусад үлдэц, ном зохиол зэрэг зүйлсийг хэлнэ.

Алхам 1 Хайр сэтгэл эсээнээс сонгож авсан өгүүлбэрүүдийг баримт, дүгнэлт, бодол эргэцүүллийг аль нь болохыг гэж тэмдэглээрэй.

- | | | | |
|--|---------------------------------|----------------------------------|-------------------------------------|
| 1. Цэцэг тарих болсноор хүн төрөлхтөн олон зууныг элээжээ. | <input type="checkbox"/> баримт | <input type="checkbox"/> дүгнэлт | <input type="checkbox"/> үзэл бодол |
| 2. Цэцэг хайр сэтгэл хоёр шиг эмзэг юм ховор. | <input type="checkbox"/> баримт | <input type="checkbox"/> дүгнэлт | <input type="checkbox"/> үзэл бодол |
| 3. Хайр сэтгэлд хар өнгө байдаггүй юм чинь хар цэцэг яаж ч байх билээ дээ хэмээн бодогддог. | <input type="checkbox"/> баримт | <input type="checkbox"/> дүгнэлт | <input type="checkbox"/> үзэл бодол |
| 4. Цэцгэнд хандаж буйгаар нь энэ бүхэн илэрнэ. | <input type="checkbox"/> баримт | <input type="checkbox"/> дүгнэлт | <input type="checkbox"/> үзэл бодол |
| 5. Зарим хүн цэцэг гишгэчих вий хэмээн цэрвэж явдаг байхад зарим нь сайхан цэцэг хармагц дуу алдан ухасхийн тасдаж авна. | <input type="checkbox"/> баримт | <input type="checkbox"/> дүгнэлт | <input type="checkbox"/> үзэл бодол |

Алхам 2 “Үнэр идэгч” эсээний баримт, үзэл бодлыг уншаад, тохирох хүснэгтэд байрлуулаарай.

1 Үнэрийн хэлийг бүрэн судалсан цагт амьтны ертөнцөд аюул учрах болно

2 Одоо бол хүн хиймэл үнэр гарган авч түүгээрээ гоёж гооддог болжээ.

3 Үүгээрээ хүн адгууснаас их хол явж, гоо сайхны үнэр идэгч болон хувирчээ.

4 Тэр нууц үнэрийг танин мэдсэнээ ашиглан, өсгөж үржүүлэх боломж нээгдэх юм.

5 Хэдэн зуун хослолоос бүрдсэн өвөрмөц үнэрээр загас баримжаа авч ирэх болсон байна.

6 Одоо үнэрийн хэлний үгийн сан, цагаан толгойг судалж байна.

Байрлуулах хүснэгт:

Баримт

Үнэрийн буюу химийн хэл гэгч бүхэл бүтэн систем нэмэгдлээ

Үзэл бодол

Амьтны үнэрийн хэлийг мэдэхийн тулд амьтны үнэрийн химийн бүрэн кодыг танин мэдвэл зохино

Алхам 3 “Үнэр идэгч” эсээнд дээрх баримтуудыг ямар зорилгоор оруулсныг дүгнэж бичээрэй.



Алхам 4 Дараах баримтыг уншаад зохиогч үнэрийн хэлийг ашиглаж ямар шийдэлд хүрч болохыг санал болгосныг өөрийнхөө үзэл бодолтой холбон дүгнэж бичээрэй.

Ургамлын хортон шавжийг жигшээх үнэрийг хэрэглэж чадвал янз бүрийн хор цацахгүйгээр хортон шавжнаас сэрэмжилж болно. Ийнхүү үнэртнээр тогтоосон хил хязгаарыг ямар ч үед хортон шавж давж гарахгүй болно. Эсвэл ялаа шумуулын дуртай үнэрийг гарган авч, түүний тусламжаар ойр хавийн ялаа шумуулыг дуудан цуглуулж устгаж болно.



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр

Хатангир

Хатангир хүн гэж ярьдаг. Хэтэрхий турсан бараг л яс арьс болчихсон эцэнхий морийг ч бас хатангир гэдэг. Хатангир хүн, малын аль нь ч гэсэн эрүүл биетэйн шинж биш юм. Тэгвэл нэг хүн юм уу нэг адуу биш бүхэл бүтэн дэлхий маань хатангирч байна гэвэл үнэмшихүйеэ амаргүй санагдаж мэднэ. Гэвч бөмбөрцөг дэлхий маань хорьдугаар зуунд айхтар их хатангиршлын өвчтэй болчихоод байна. Насны эрхээр хатангир болж мах булчин нь шуугдаж байгаа хүнийг бие махбод усгүйжих үйл явцад эргэлтгүй орсон хэмээн эмч нар оношлох дуртай. Усгүйжих, хуурайших, хатах нь үнэн хэрэг дээрээ хөгшрөхийн цондон юм. Хүний бие махбодын ная хүртэл хувь нь ус гэлцдэг Шингэн зүйл болохоороо их ч амархан багасч бараг л уурших мэт алдагддагаас нас дээр гарахын өдөр хоног нь залуу цагийн сар жилтэй тэнцэхүйц утга чанартай болдог нь илэрхий. Харин мах цусанд төрсөн хүн амьтан биш, хад чулуунаас голдуу бүрдсэн дэлхий байгаль яахаараа хатангиршдаг билээ. Хэтэрхий хүнчлэн бясалгаж байна уу гэлтэй дүгнэлтийн эргэн тойронд ярих хэлэлцэх, ухаарах мэдэх юм тун их байдаг ажаам. Мах ясанд ангид биш төрсөн хүн ч, хад чулуунд төрсөн дэлхий ч ялгалгүй аль аль нь хатангиршихын аюулаас болохыг хорьдугаар зуун олон зүйлээр нотлон өгөөд одлоо. Хорьдугаар зууны эхээр эрүүл саруул галгиж, цалгиж явсан хүмүүс ч, хорвоо дэлхий ч адилхан сульдаж туйлдаж хүмүүсийн дийлэнх олонхи нь шинэ зууны барааг харж чадсангүй. Харин газар дэлхий уужим бөгөөд том юм болохоор энд тэндгүй шарх сорви олсон ч гэсэн ахиад нэгэн зууныг элээчихтэйгээ үлдлээ. Балчих нялхдаа ээжийнхээ хөхийг үлгэж хөл дээрээ тогтмогц хүмүүс “дэлхий ээж минь та мөнх настай та мөнх настай” гээд л бөмбөрцөг дэлхийнхээ шим шүүсийг сорж эхэлдэг билээ. Юуны урьд дэлхий ээжийн гадаргуугийн болоод гүний усыг сорж өл залгуулна. Хүн гэгчийн хоёр алд биетэй харьцуулахад дэлхий мань тэвэрч барахгүй том юм болохоор хэдэн тэрбум хөвгүүдийг ч хэдэн зуундаа ундлах бэнчинтэй ажээ.

“Хорвоо дэлхий уужим, ховоодож барахгүй устай гэж ярьдаг. Тэр уул нь үнэн. Хорвоод ус элбэг заяажээ. Гачлантай нь хорвоогийн бүх усан баялгийн 99.3% нь шорвог юм. Дөнгөж 0.7% нь цэнгэг ус болохоор шорвог ус ходоодонд үл тогтдог хүн гээч амьтан хөөрхий еэ. Бас давстай усанд дасдаггүй өвс ургамал, ой хөвч хөөрхий еэ. Тариа ногооны тухайд ч хэлэх үг байхгүй. Давстай усанд ургана гэж үгүй. Ингээд бодохоор цэнгэг ус гэгч ховор эрдэнэ, дэлхийн хүн амьтан, өвс ургамлын томоохон гачигдал нь болж байдаг буюу. Тэр гачигдал ямарваа засгийн газар, ямарваа нийгмийн хэвшил мэтийг огтхон ч тоож хэлэлцдэггүй дархан эрхтэй хэрэглээний хявцал юм....

Л.Түдэв


1. Эсээний эхлэл хэсэг аль хүртэл байгааг олоорой.
 - A. Хатангир хүн гэж..... мэднэ
 - B. Хатангир хүн гэж байна.
 - C. Хатангир хүн гэж гэдэг
 - D. Хатангир хүн гэж шинж биш
 - E. Хатангир хүн гэж цондон юм.
2. Эсээг эхлэхдээ уншигчдын анхаарлыг ямар сонирхолтой мэдээллээр татсан бэ?
 - A. Хүний бие махбодын ная хүртэл хувь нь ус гэлцдэг .
 - B. Яс арьс болчихсон эцэнхий морийг хатангир гэдэг.
 - C. Бүхэл бүтэн дэлхий маань хатангирч байна.
 - D. Хатангир хүн, малын аль нь ч гэсэн эрүүл биетэйн шинж биш
 - E. Усгүйжих, хуурайших, хатах нь үнэн хэрэг дээрээ хөгшрөхийн цондон юм.
3. Эсээний хөтөч санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.
 - A. Бөмбөрцөг дэлхий маань хорьдугаар зуунд айхтар их хатангиршлын өвчтэй болчихоод байна.
 - B. В. Мах цусанд төрсөн хүн амьтан биш, хад чулуунаас голдуу бүрдсэн дэлхий байгаль яахаараа хатангиршдаг билээ.

- С. Юуны урьд дэлхий ээжийн гадаргуугийн болоод гүний усыг сорж өл залгуулна.
- D. Тэгвэл нэг хүн юм уу нэг адуу биш бүхэл бүтэн дэлхий маань хатангирч байна гэвэл үнэмшихүйеэ амаргүй санагдаж мэднэ.
- E. Хүн ч, хад чулуунд төрсөн дэлхий ч ялгалгүй аль аль нь хатангиршихын аюулаас болохыг хорьдугаар зуун олон зүйлээр нотлон өгөөд одлоо

4. Эсээнд дэвшүүлсэн асуудлыг олоорой.

- A. Усгүйжих хатах тухай
- B. Хатангирших өвчний тухай
- C. Эцэнхий туранхай хүн, амьтны тухай
- D. Дэлхий минь хатангиршиж буй тухай
- E. Хорьдугаар зууны аймшигт өвчний тухай

5. Эсээнд юуг харьцуулсныг гүйцээж бичээрэй.



6. Дараах өгүүлбэрт онцолсон холбох үгээр юуг эсрэгцүүлж харуулсан бэ?

Харин газар дэлхий уужим бөгөөд том юм болохоор энд тэндгүй шарх сорви олсон ч гэсэн ахиад нэгэн зууныг элээчихтэйгээ үлдлээ.

- A. Хорьдугаар зууны эхээр хүмүүс эрүүл саруул галгиж, цалгиж явсан ч, шинэ зууны барааг харж чадаагүйг
- B. Хүмүүс шинэ зуунтай золгож чадаагүй ч газар дэлхий уужим болохоор энд тэндээ шарх сорвитой ч тэсэж үлдсэн гэдгийг
- C. Газар дэлхий энд тэндээ шарх сорви олсон ч хэдэн зууныг элээхтэйгээ байгааг
- D. Хорьдугаар зууны эхээр хүмүүс эрүүл саруул галгиж, цалгиж явсан хүмүүс ч, газар дэлхий ч адилхан туйлдаж байгааг
- E. Дэлхий туйлдаж, хүмүүсийн дийлэнх олонхи нь шинэ зууны барааг харж чадаагүйг

7. Дараах өгүүлбэрүүдийг зөв харгалзуулаарай.

- | | |
|--|----------------------|
| 1. Ингээд бодохоор цэнгэг ус гэгч ховор эрдэнэ, дэлхийн хүн амьтан, өвс ургамлын томоохон гачигдал нь болж байдаг буюу | a. Таамаглал |
| 2. Бас давстай усанд дасдаггүй өвс ургамал, ой хөвч хөөрхий еэ. | b. Баримт |
| 3. Тэр гачигдал ямарваа засгийн газар, ямарваа нийгмийн хэвшил мэтийг огтхон ч тоож хэлэлцдэггүй дархан эрхтэй хэрэглээний хявцал юм | c. Үзэл бодол |
| 4. Хүн юм уу нэг адуу биш бүхэл бүтэн дэлхий маань хатангирч байна гэвэл үнэмшихүйеэ амаргүй санагдаж мэднэ. | d. Хандлага өнгө аяс |
| 5. Хорвоогийн бүх усан баялгийн 99.3% нь шорвог юм | e. Дүгнэлт |
- A. 1c 2d 3e 4a 5b B. 1d 2c 3e 4a 5b C. 1c 2e 3d 4a 5b D. 1c 2d 3a 4b 5e


Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Даалгавар 1 Холимог нийлмэл өгүүлбэрийн утга, бүтэц, үүрэг хэрэглээг тайлбарлах



Монгол хэлний нийлмэл өгүүлбэр нь зөвхөн зэрэгцүүлэх холбоонд суурилсан зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр, зөвхөн угсруулах холбоонд суурилсан угсарсан нийлмэл өгүүлбэр гэх зэрэг дан ганц холбоонд суурилсан нийлмэл

өгүүлбэрүүд байхаас гадна эдгээр хэв маяг холилдож орсон хэв шинжтэй байх нь буй. Холимог нийлмэл өгүүлбэр гэдэг нь бүтцэдээ гурав ба түүнээс дээш энгийн өгүүлбэр багтааж, тэдгээр нь өөр хоорондоо өөр өөр хэв маягаар \зэрэгцүүлэх, угсруулах , харилцан угсруулах гм\ холбогдож хэлбэр ба утгын хувьд нэгэн бүхэл болсон өвөрмөц хам бүтэц юм.



Алхам 1 А. Энгийн өгүүлбэр болгон заагласан өгүүлбэрүүдийн холбогдсон аргыг нь бичээрэй. **Жишээлбэл:** “Ургамлын хортон шавжийг жигшээх үнэрийг хэрэглэж чадвал янз бүрийн хор цацахгүйгээр хортон шавжнаас сэрэмжилж болно.” гэсэн өгүүлбэрийг хэрхэн ажилласныг хараарай.

Ургамлын хортон шавжийг жигшээх (-х угсруулан холбох нөхцөл)

үнэрийг хэрэглэж чадвал (-вал угсруулан холбох нөхцөл)

хортон шавжнаас сэрэмжилж болно.


янз бүрийн хор цацахгүйгээр (угсруулан холбох нөхцөл)

- 1) Тэр зарыг авмагц (_____) мөнөөхөн ургамлууд бас л муухай үнэр гаргадаг байна.
- 2) Зөгий гэхэд л зунжин намаржин цэцэгнээс цэцэг дамжин, (_____) бал цуглуулж (_____) өвөлд бэлтгэдэг.
- 3) Зарим ургамал хортон шавж хүрэлцэн очиход нь (_____) мөчир салаанаас муухай үнэр гаргаж (_____) тэр хорхойнуудыг хөөн жигшээдгээр барахгүй (_____) энэ аюулын тухай ойр хавьдаа зар тараадаг байна.

Б. Өгүүлбэрүүд юугаар холбогдсоныг олоорой

- A. Дан угсруулан холбох нөхцөлөөр
 B. Дан зэрэгцүүлэн холбох нөхцөлөөр
 C. Зэрэгцүүлэн холбох, угсруулан холбох нөхцөлөөр
 D. Дан угсруулах холбох үгээр
 E. Дан зэрэгцүүлэн холбох үгээр

Алхам 2 Загваруудад тохирох өгүүлбэрүүдийг алхам 1-ийн даалгавраас олж, дугаараар нь харгалзуулаарай.



Алхам 3 А. Холимог нийлмэл өгүүлбэрийг гол өгүүлбэр, гишүүн өгүүлбэрээр нь ялгаж бичээрэй. **Б.** Гол өгүүлбэрийн хэв маягийг тодорхойлоорой.

Хулгана болохоор зунжин идэхийн хамт мөн л өвөлд бэлтгэн, хөөгөө хураадаг.

- A. Гишүүн өгүүлбэр: _____ Гол өгүүлбэр: _____

Б. Гол өгүүлбэр нь _____ - гэсэн _____ -холбох нөхцөлөөр холбогдсон тул _____ нийлмэл өгүүлбэр байна.

Алхам 4 Цэгийн оронд доор өгсөн нөхцөл, холбох үгээс тохирохыг нь сонгон найруулж, холимог нийлмэл өгүүлбэр бүтээгээрэй.

Зарим хүн цэцэг гишгэчих вий хэмээн цэрвэж явдаг бай(...), зарим нь сайхан цэцэг хар(...) дуу алдан ухасхийн тасда(...) авч энгэртээ хатгахыг боддог.

Сонгох нөхцөл, холбох үг: -н -х үед -магц -ж -х-д

Алхам 4 Дараах төгс өгүүлбэрүүдийг холимог нийлмэл өгүүлбэр болгон найруулж бичээрэй.

- A. Хортон шавж хүрэлдцэн очдог аж. B. Тэр нь хорхойнуудыг жигшээн хөөнө
 Б. Зарим ургамал мөчир салаанаасаа муухай үнэр гаргана.

1. Өгүүлбэрүүдийг тохирох тодорхойлолтод харгалзуулаарай.

- | | | |
|---|----|------|
| a) Шинжлэх ухааны тусламжаар янз бүрийн гоё үнэртэн үйлдвэрлэж, түүгээр орчин үеийн эмэгтэйчүүд гангалан гоёж байна | 1. | ХоНӨ |
| b) Харин босоо явах болсноор хүн хамраа сөхсөн хэрэг. | 2. | ЭӨ |
| c) Гэвч хүн босоо явдаг болсноос хойш дээр хэлснээр үнэрээс холдож, хамрын чадвар суларчээ. | 3. | ЗНӨ |
| d) Эх нь үрээ үнэрээр нь танина. | 4. | УНӨ |

A. a3, b4, c1, d2

Б. a4, b3, c1, d2

В. a2, b1, c4, d3

2. Аль нь холимог нийлмэл өгүүлбэр вэ?

A. Гэтэл нохой мөн тийм хэмжээний агаарт 9000-хан молекул үнэр байхад л мэдэрч чадна.

В. Хургаа голсон хонь, ботгоо голсон ингэ бодвол хургаа, ботгонд өөр гаж үнэр шингэснээс болдог биз.

С. Үнэр шинжих ухаан буюу одорологийн тусламжтайгаар янз бүрийн гоё үнэртэн үйлдвэрлэж байна.

D. Амьтны үнэрийн хэлийг бүрэн судалж дуусах үед хүн адгуус хоёр бие биеэ улам гүнзгий ойлгодог болно.

Е. Хүний бие хөрж даарахыг хамгийн түрүүн хамар мэдэрч найтааж, дохио өгдөг.

3. Цэгийн оронд аль нөхцөлийг сонговол ХоНӨ болох вэ?

Хүн дөрвөн хөллөж явдаг байхдаа хамраараа бүх мэдээллийн 80%-аас доошгүй хувийг авдаг байсан (...) дөрвөн хөлт амьтад одоо ч тийм хэмжээний мэдээлэл хамраараа авдаг хэвээр юм.

A. авч

В. тул

С. бөгөөд

D. харин

4. Дараах бодомжуудаас холимог нийлмэл өгүүлбэрийн хэв шинжид тохирохыг сонгоорой.

A. Дан угсруулан холбох нөхцөлөөр хэлбэржсэн байна.

В. Нэг өгүүлбэр нь голлож, нөгөө нь дагуул үүрэгтэй байна.

С. Өгүүлбэрүүд нь бие биенээсээ шалтгаалцсан утгатай байна.

D. Зэрэгцүүлэх, угсруулах холбоос аль аль нь орсон байна.

Е. Дан зэрэгцүүлэн холбох нөхцөлөөр хэлбэржсэн байна.

5. Дараах өгүүлбэрийг шалтгааны утгат гишүүн өгүүлбэрээр дэлгэрүүлж бичихэд аль нь тохирох вэ?



(_____) Цөс ялгарах нь багасаж, шүд үйрэмтгий болж, цусанд гемоглобин буурна.

A. Хүн хамраа бөглөсөн ч

В. Хүн хамраа бөглөөд байвал

С. Хүн хамраа бөглөх бөгөөд

D. Хүн хамраа бөглөж

Е. Хүн хамраа бөглөн

6. Энгийн өгүүлбэрүүдийг холимог нийлмэл өгүүлбэр болгон, найруулж бичээрэй.


Хамар хүний гол эрхтэн юм. Иймээс оюуны хөгжлийн гол эх үүсвэрийг тавьсан гэдэг. Энэ нь маргашгүй үнэн ажээ.

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Даалгавар 1 Эсээний эхлэл хэсэгт асуудал дэвшүүлж, хөтөч санаагаа бичих



Эхлэл хэсгийг бичихдээ дараах алхмаар гүйцэтгэнэ. Үүнд:
 1. Уншигчийн анхаарал татах 2. Суурь мэдээлэл өгөх 3. Хөтөч санаагаа бичих
 Ингэхдээ эхлээд эсээ бичих зорилгоо тодорхойлж, юуны тухай, хэнд зориулж бичихээ төлөвлөсөн байх хэрэгтэй. Үүний дараа уншиж судалсан зүйл, цуглуулсан баримт мэдээлэлдээ тулгуурлан сэдэв, гол асуудлаа тодорхойлох нь чухал бөгөөд сэдэв , гол санааг нэгээс хоёр өгүүлбэрт төвлөрүүлж, хөтөч санаагаа бичнэ.
Асуудал дэвшүүлэх: Дэвшүүлсэн асуудал нь хэт ерөнхий биш тодорхой байх нь чухал. Жишээлбэл: Жишээ нь: М.Тулгат “Мөнгө” эсээнд асуудлаа хэрхэн дэвшүүлснийг харъя.



Алхам 1 Загварыг ажиглаад, цэгийн оронд нөхцөл байдал, зорилгыг үргэлжлүүлэн нөхөж бичээд , өөр ямар асуудал дэвшүүлж болохыг таамаглаарай.



Алхам 2 Дараах ерөнхий сэдвүүдээс тодорхой сэдэв сонгож бичиж туршаарай.

a) Эрүүл мэнд

.....

b) Боловсрол

.....

c) Байгаль орчин

.....

Алхам 3 Алхам 2-д тодорхойлсон сэдвээс аль нэгийг нь сонгож асуудлаа тодорхой болгоорой.


Өнөөгийн нөхцөл байдал?	Асуудал	Чи юу хүсэж байна вэ? \зорилго\
.....

Алхам 4 а. Хөтөч санааг яаж бичих талаар уншаарай.



Эргэцүүлсэн эсээний хөтөч санаа нь уг сэдэв, асуудлын талаар зохиогчийн хэлэх гэсэн гол санааны хураангуй илэрхийлэл юм. Үүнийг үндсэн хэсэгт баримт мэдээллээр дэмжин дэлгэрүүлж бичдэг тул эсээг бичих явцад хөтөч болж, бичих зүйлээ бүхэлд нь хянахад тус болно.

Хөтөч санаа нь:



б. Хөтөч санаагаа илэрхийлж бичээрэй.



Алхам 6 Хөтөч санааг хэр зэрэг оновчтой тодорхойлсноо дараах шалгуурын дагуу тэмдэглэл хийж, өөрийгөө үнэлээрэй.

Шалгуур	Сайн хийсэн	дутуу	Огт чадаагүй
1. Гол асуудлаа \сэдэв\ тусгасан уу?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2. Гол санаагаа хураангуй илэрхийлсэн үү?	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3. Өөрийн байр сууриа тусгасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Дууссан:онсарөдөр

Даалгавар 2 Эсээний гол ба төгсгөл хэсгийг бичих



Эргэцүүлсэн эсээний үндсэн хэсгийг бичихийн тулд гол асуудлыг олон талаас нь харьцуулан дүгнэж болохуйцаар судалгаа хийж баримт мэдээлэл цуглуулж, асуудлыг эерэг, сөрөг талаас авч үзэж болохоор бичих дэс дараалалд оруулна.

Мөн өөр бусад хүмүүсийн үзэл бодол байр суурийг харгалзан үзэх, эдгээрт өөрийн зүгээс үнэлгээ дүгнэт өгөх хэрэгтэй. Төгсгөлд нь үзэл бодлоо дахин илэрхийлэж дүгнэлтээ бичнэ.

Жишээлбэл: М.Тулгат “Мөнгө” эсээнд адилхан өлсгөлөн, ядуурал нүүрлэхэд нэг үндэстэн нь хулгай худал руу хошуурцгааж байгааг монголчуудын жишээгээр, нөгөө үндэстэн нь хөдөлмөр, хичээл зүтгэл рүү зүглэж байгааг хууль дүрмээ зөрчихгүйг баримталсаар байгаад өлсөж үхсэн япон албан хаагчийн түшмэлийн тухай баримтаар эсрэгцүүлэн харуулжээ.

Алхам 1 а. Эсээний бүтцээс хөтөч санаа, дэмжсэн цогцолборуудын тухай уншаарай.

б. 3-р цогцолборыг баримтаар дэлгэрүүлж бичээрэй.

в. 2-р цогцолборын санааг дэмжсэн нэг цогцолбор нэмж бичээрэй.

Хөтөч санаа:

Гэмт хэрэг ёс суртахуун доройтол ядуу нийгэмд газар авдаг нь үнэн. Гэхдээ үүнийг хавтгайруулан, хүлээн зөвшөөрч, ядууралд дулдуйдан “зөвтгөмгүй” санагдана.

эсрэг үндэслэл

Цогцолбор 3

Монголд мөнгөтэй болох тусмаа далайцтай гэмт хэрэг хийж, шүүх хуулийг худалданавч “нүгэл хилэнцээ арвижуулж” байгаа нөхдүүд цөөнгүй бий.

Баримт:

.....
.....
.....
.....

Цогцолбор 1

Дэлхийн хоёрдугаар дайны дараах Япон улсын бүх нөөц шавхагдан өлсгөлөнгөөр нэрвэгдсэн он жилүүдэд хуулийн албан хаагч түшмэл “би өөрөө хууль зөрчвөл юу болох билээ” гэж итгэл үнэмшлээ хадгалсаар өлсөж үхсэн тухай дурсамж

эерэг үндэслэл

Цогцолбор 2

Ерөөс дайны дараах япончууд амьдрахын төлөө үнэн цагаанаар зүтгэцгээсэн байна. Нэг өвгөнөөс асуухад “тэр үед хүн бүр эрвийх дэрвийхээр хөдөлмөрлөж, олдсон жажнаа хавь ойрынхондоо хуваадаг байсан” гэж ярьжээ

Цогцолбор 4

.....
.....
.....
.....

?

Алхам 2 Эсээний бүтцээс хөтөч санааг дэмжсэн цогцолборуудыг ажиглахад зохиогчийн үзэл бодол аль талд байгааг бичээрэй.



Алхам 3 Эсээний төгсгөл хэсгийн дүгнэлт өгүүлбэр ямар байхыг бичээрэй. Чиний өөрийн үзэл бодол аль талд байна вэ?



Алхам 4 Дараах эшлэлүүдээс асуудал дэвшүүлэн “Эх хэлний дархлаа” сэдвээр, үе тэнгийхэндээ зориулсан эргэцүүлсэн эсээ бичээрэй.

...Хэл мөхөх үндсэн хоёр шалтгаан бий. Нэгд, тухайн хэлээр хэлэлцэгч үндэстэн үгүй болоход хэл нь дагаж мөхнө. Цагаан арьстнууд Америк, Австрали тивд суурьшигдаа Уугуул нутгийн олон үндэстэн ястныг хэлнийх нь хамт “бурхан болгосон” нь гашуун үнэн. Уг үндэстэн нь оршин байвч өөр соёлд ууссанаар хэл үгүй болох нь хэлний мөхлийн хоёр дахь шалтгаан. | Л. Түдэв. Хэлний мөхөл |

Хэлний дархлаанд хамгийн их нөлөөлдөг зүйл бол бичиг үсэг. Бичиг үсэг хэлний хөгжлийн хурдыг сааруулж, дархлааг нь бэхжүүлдэг. Тийм ч учраас бичиг үсгээр баталгаажсан хэл мөхөх аюулаас хол.

Өдөр тутамдаа ариун тансаг, уран зохиолын хэлээр яриад байгаа нь багасаж байна. Ялангуяа интернэт орчинд эх хэлний дархлаа мөн ч их унаж байна гэхэд хилсдэхгүй.

Ер нь монгол хэл цөөн хэрэглэгчтэй ч дархлаа сайтай хэл юм. Үүссэнээсээ хойш гурван цагийн хэлхээнд хэрэглэгч нь тасраагүй, нэн эртнээс бичгийн хэлээр дархлаажсан хэлний нэг юм.
Ц. Өнөрбаян

Сурагчийн нэр:


Эхэлсэн: он сар өдөр



Толь бичиг нь өөрийн зорилго, үүрэг шаардлагаас үүдэн янз бүр байж болох бөгөөд ерөнхий шинжээр нь нэвтэрхий толь, хэл шинжлэлийн толь гэж ангилдаг байна.

Нэвтэрхий толь: Байгаль нийгмийн элдэв үзэгдэл, ойлголт, түүхэнд, тодорсон онцгой үйл явдал, газар нутаг, улс орон, хувь хүний тухай холбогдох материалыг баримтжуулан хураангуй хэлбэрээр тайлбарлан бичсэн байдаг. Хэрэглээ, үүрэг, зориулалтаараа бүх нийтэд зориулагдсан ерөнхий нэвтэрхий толь, мэргэжлийн хүмүүсийн хэрэгцээнд зориулсан тусгай нэвтэрхий толь гэж байдаг аж.

Хэл шинжлэлийн толь: Энэ нь өөрийн агуулга, хэмжээ, шинж чанараараа олон янз байх бөгөөд нэг хэлний болон олон хэлний хэл шинжлэлийн толь гэж ангилна. Нэвтэрхий тольд юм үзэгдлийг онол болоод практикийн хувьд шинжлэх ухааны дээд түвшинд тайлбарласан байдаг бол хэл бичгийн ухаан тольд зөвхөн үгийн утгыг тайлбарласан байдаг онцлогтой.



Даалгавар 1 Толь бичгийн үүрэг хэрэглээг уншиж ойлгох

Алхам 1 Баримтуудыг уншаад, ямар тольд хамаарахыг харгалзуулаарай.

<p>1. Зүрх- Зүрх судасны тогтолцоо буюу цусны эрхтний гол эрхтэн. Зүрх бол өөр лүүгээ цутгах венийн судсаар орох цусыг хүлээн авч, улмаар тэр цусыг уушгиар дамжуулан артерийн судсаар бие эрхтэнд тараадаг. Зүрх нь цээжний хөндийн зүүн тал, өвчүүний арын хэсэгт байрладаг... Насанд хүрсэн эрэгтэй хүний зүрх дунджаар 322-340гр, эмэгтэй хүнийх 250-280гр орчим байна. Зүрх хөндлөнгөөрөө 9-11см, урд, ард хэсэг нь 6-8 см, урт нь 10-15 см, тосгуурын хананы зузаан дунджаар 9-11мм орчим байна... \ толиос хэсэглэн авав \</p>	<p>А. Олон хэлний орчуулгын толь</p>
---	--------------------------------------

<p>2. 2.1. Зүрх 1. Хүн амьтны цусны эргэлтийн гол эрхтэн: зүрх дэлсэх (зүрх түг түг хийх) - Өвчтөний зүрх нь дэлсэж, амьсгаа нь давхцан эхлэв. “Эрүүл мэнд” сэтгүүлээс: зүрх судас хоршоо (хүн амьтны цусны эрхтний гол эрхтэн болоод цус гүйх гуурс) ...2. Зориг цөс: зүрх алдах (айж төвөгшөөх) - хэлтсийн даргын ширүүн харцнаас зүрх алдаад байна. “Утга зохиол урлаг” сонин: 3. Гол чухал: амин зүрх (амин гол)- Миний амин зүрх тэр явж байна. С. Эрдэнэ “Хулан бид хоёр”. зүрхний угаас (нэн дотноор сэтгэлээсээ) (...толиос хэсэглэн авав)</p>	<p>В. Нэвтэрхий толь</p>
<p>3. 2.2 Зүрх 1. сердце: зүрхний цохилт стук сердца сердцебиение: зүрх шархлах а\ ранить в сердце: б\ нанести сердечную рану: в\ причинить душевную боль: 2. перен. Сердечность, смелость отвага: Үүнийг хийхийн тулд зүрх хэрэгтэй. Это сделать нужна смелость : зүрх алдах потерять присутствие духа: пасть духа (букв. Сердце упустить)</p>	<p>С. Хэл шинжлэлийн толь</p>

Алхам 2 Эдгээр тольд “зүрх” гэдэг үгийг хэрхэн тайлбарласныг нөхөж бичээрэй.

Хэл шинжлэлийн тольд “зүрх” гэдэг үгийн болон утгыг тайлбарласан байна.

Нэвтэрхий тольд “зүрх” гэдэг хүний эрхтний онцлог шинж, үүргийг -ны үүднээс тайлбарласан.

Олон хэлний орчуулгын тольд “зүрх” гэдэг үгийн утгыг, хэлээр тайлбарласан


Алхам 3 Толь бичгүүдийн ялгааг өөрийнхөө ойлгосноор тайлбарлаж бичээрэй.



Алхам 4 Толь бичгийн тайлбарыг уншаад, алинд нь хамаарахыг сонгоорой.

Ерөнхий толь

Тусгай толь



Бага гарын хураангуй\, ерөнхий боловсролын сурагч хүүхдэд зориулсан, суурь мэдлэгийн чиглэлтэй



Дунд гарын \товч\ ажил мэргэжлийн салбар ухааны хүмүүс, оюутан залууст зориулсан,

Дууссан:онсарөдөр

Алхам 5 Харь үгийн тольд буй үгийн тайлбарыг тохирох дугаарт зөв оноосон нь аль вэ?

ДЭВТЭР

перс. daftar; мо.б; (тө: deb-ther; манж; debtelin):
цаас давхарлан үдээслэн товхисон бичигтэй буюу бичиггүй цаас

О. Сүхбаатар. Харь үгийн толь. УБ., 1997, 148-р тал.

1 → 2 → 3 → 4 → 5

- A. Аль хэлний үг болохыг бичнэ B. Үгийн утгын тайлбар C. Толгой үг
D. Ойролцоо бичиж, дууддаг хэл E. Монгол бичгээр бичнэ
A. 1C 2A 3E 4B 5D B. 1A 2C 3E 4B 5D C. 1E 2A 3C 4B 5D D. 1C 2A 3D 4E 5B

Монгол хэл

11

Нэгж хичээлийн агуулгын хүрээнд сурсан мэдсэнээ сориорой.

1. Цэгийн оронд аль нь тохирох вэ?

.....толь нь юм үзэгдлийг онол болоод практикийн хувьд шинжлэх ухааны дээд түвшинд тайлбарласан байдаг.

- A. Хэл шинжлэлийн толь B. Ерөнхий нэвтэрхий толь C. Тусгай толь
D. Олон хэлний буюу орчуулгын толь E. Нэг хэлний тайлбар толь

2. Их гарын дэлгэрэнгүй, бүх нийтэд зориулсан, ерөнхий, аль мэргэжлийн хүн ашиглаж болох толь бичиг нь аль вэ?

- A. Монгол хэлний толь.(ЕБС-ийн сурагчдын хэрэглээнд)
B. Монгол хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь
C. Монгол-Англи, Англи-Монгол өврийн толь
D. Анагаах ухааны танин мэдэхүйн толь
E. Монголын үндэсний нэвтэрхий толь

3. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичгийн толгой үгэнд орсон 1,2,3 гэсэн араб тоогоор юуг ялган тэмдэглэдэг вэ?

- A. Тухайн үгийн олон утгыг тэмдэглэнэ.
B. Тухайн үгийн үгсийн аймгийг тэмдэглэнэ.
C. Шинжлэх ухааны нэр томъёоны утгыг тэмдэглэнэ.
D. Хоршоо үгийн утгыг тэмдэглэнэ.

4. Бага гарын хураангуй, ЕБС-ын сурагчдад зориулсан толь бичигт тохирох шинжүүдийг олж, “+” гэж тэмдэглээрэй.(2-оос дээш хариу сонгоно.)

- | | | | |
|--------------------------|---|--------------------------|---------------------------------------|
| <input type="checkbox"/> | Толгой үгийн тоо олон | <input type="checkbox"/> | Номын санд голдуу байдаг |
| <input type="checkbox"/> | Идэвхтэй хэрэглээний үг хэллэг орсон | <input type="checkbox"/> | Тайлбар дэлгэрэнгүй (баримт жишээтэй) |
| <input type="checkbox"/> | Олон талын мэдээлэл агуулсан | <input type="checkbox"/> | Толгой үгийн тоо цөөн |
| <input type="checkbox"/> | Тухаан мэргэжлийн нэр томъёо орсон | <input type="checkbox"/> | Цөөн мэдээлэл (зөв бичих, дуудах гм) |
| <input type="checkbox"/> | Цүнх, өвөр халаасанд авч явахад тохирох | <input type="checkbox"/> | Голдуу хоёроос дээш олон ботилсон |

5. Алиныг нь толь бичигт том үсгээр тодруулан бичиж, ром тоогоор дугаарыг тэмдэглэдэг вэ?

- A. Хоршоо үг B. Хэлц үг C. Үгийн аймаг D. Толгой үг E. Нэрт томъёо

Дууссан:онсарөдөр

Зураглал

